МОНГОЛ УЛС:
ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ СУДАЛГАА

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC

IOM UN MIGRATION

UNITED NATIONS UNIVERSITY
UNU-MERIT

PTRC

Тайланд тусгасан дүгнэлтүүд нь зохиогчдын үзэл бодол бөгөөд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын (ОУШХБ) байр суурийг төлөөлөхгүй. Тайланд буй бүхий л тодорхойлолт болон үзүүлэх материал нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин болон эдгээрийн удирдлагын эрх зүйн байдал, хил хязгаарын талаарх ОУШХБ–ын үзэл санааг илэрхийлээгүй болно.

ОУШХБ хүнлэг энэрэнгүй, эмх журамтай шилжилт хөдөлгөөн нь шилжин суурьшигчид болон нийгэмд сайн сайхныг авчирна гэсэн зарчимд итгэдэг. Засгийн газар хоорондын байгууллагын хувьд ОУШХБ нь олон улс дахь түншлэгч талуудтайгаа хамтран, шилжилт хөдөлгөөний явц дахь бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд туслах, шилжилт хөдөлгөөний асуудлын талаарх ойлголтоо дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих болон шилжин суурьшигчдын нэр хүнд, сайн сайхныг хамгаалан дэмжиж, туслахын төлөө ажилладаг.

Энэхүү хэвлэл нь Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллагын хэвлэлийн албаар баталгаажаагүй болно.

Хэвлэсэн: Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага Нэгдсэн Үндэсний Байгууллагын байр, Нэгдсэн Үндэсний гудамж – 14 Улаанбаатар–14201 Монгол улс Утас: +976 701 43100 Цахим шуудан: AllUsersinUlanbator@iom.int

© 2018 Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)

Зохиогчийн эрхийг хуулиар баталгаажуулсан. Тус хэвлэлийн зохиогчоос урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр хэвлэлийг бүхлээр нь болон аливаа хэсгийг дахин хэвлэх, хайлтын системд байрлуулах мөн электрон хэлбэрээр, гараар хуулбарлан, хувилагч машинаар хуулбарлах, бичлэг хийх болон бусад аргаар дамжуулан мэдээлэхийг хориглоно. Энэхүү тайланд ОУШХБ–ын албан ёсны редакц хийгдээгүй болно.

МОНГОЛ УЛС:
ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ СУДАЛГАА

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC

IOM UN MIGRATION

UNITED NATIONS UNIVERSITY
UNU-MERIT

PTRC

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад хүн төвтэй бодлогын боловсруулалтыг дэмжиж, суурь мэдээлэл болгох зорилгоор «Монгол Улс: Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа» хэмээх анхны үндэсний хэмжээний цогц судалгааг толилуулж байгаадаа баяртай байна.

Уугуул нутаг, шилжин суурьшсан нутгийн шилжигч, шилжигч бус мянга гаруй өрхөөс мэдээлэл цуглуулсан энэхүү судалгаа нь Монгол улсын дотоодын шилжилт хөдөлгөөний онцлог, мөн чанарын тухай бидний мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэн баяжуулж байна. Шилжигчдийн үндсэн шинж чанар, шилжих хөдөлгөөний хөдөлгөгч хүчин зүйлс, шилжин суурьшсан газар нутаг дахь шилжигч хүн амын нөхцөл байдал зэрэг нарийвчилсан сэдвүүдийг хөндсөн. Мөн энэхүү судалгаа нь шилжигч, шилжигч бус өрхүүдийн боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, ажил хөдөлмөр эрхлэх боломж, дэд бүтэц, орон сууц, ус, ариун цэврийн байгууламжаас үүдэлтэй амьдралын чанарын дүр төрхийг харьцуулан гаргасан.

Шилжигсдийн дийлэнх нь гэнэтийн үйл явдлын улмаас бус, эдийн засаг, амьдралынхаа нөхцөлийг сайжруулах эрмэлзэл, зорилгоос үүдэлтэйгээр шилжилт хөдөлгөөнд оролцдог болохыг судалгааны үр дүн харуулж байна. Чанартай боловсрол, эрүүл мэндийн сайн үйлчилгээ хайх, гэр бүлийн гишүүдээ дэмжих зэрэг нь дотоодын шилжилт хөдөлгөөний хөдөлгөгч хүчин зүйлс болж байгааг илрүүлжээ. Судалгаагаар шилжигсдийн олонх, шилжин шилжин суурьшсан нутагтаа ирээд нөхцөл байдал нь сайжирсан гэж дүгнэсэн байна. Нүүдэллэх, шилжин суурьших нь Монгол түмний аж төрөх ёсны олон мянган жилээр тогтсон уламжлал боловч орчин цагийн шилжих хөдөлгөөний хандлага нь хүн амын нэлээд хэсэг хот руу нүүж, улмаар хотжилт эрчимжиж, хөдөөгийн гал голомт уугуул нутаг эзгүйрэх үзэгдэл газар авч байгаад оршиж байна.

Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)–ын мэргэжилтнүүд тоон болон чанарын судалгааны арга зүй боловсруулахад дэмжлэг үзүүлж, Монгол Улсын судалгааны тэргүүний байгууллагуудын нэг болох Монгол улсын их сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв судалгааг гардан гүйцэтгэлээ. Швейцарийн хөгжлийн агентлаг уг судалгааг санхүүжүүлсэн болно. ОУШХБ–ын нэрийн өмнөөс, энэхүү боломжийг ашиглан, тус судалгааг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхэд хамгийн чухал хувь нэмэр оруулсан эдгээр түнш байгууллагуудад гүн талархалаа албан ёсоор илэрхийлье.

Одоо бид суурь мэдээлэлтэй боллоо. ОУШХБ нь, Монгол улсын дотоодын шилжигсэд, тэдгээрийг хүлээн авч буй нутгийнхныг дэмжих төрийн үйлчилгээ, зохицуулалтыг сайжруулах нотолгоонд суурилсан бодлого төлөвлөх, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр Монгол улсын засгийн газрыг дэмжиж ажиллахад бэлэн байна.

Richard Fairbrother

Ричард Фэрбротэр
ОУШХБ–ын Хятад болон Монгол дахь салбарын
захирлын үүрэг гүйцэтгэгч

ГАРЧИГ

ТҮЛХҮҮР ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТУУД v
ТОВЧ ХУРААНГУЙ vii
1. УДИРТГАЛ 1
1.1. Үндэслэл 1
1.2. Зорилго, зорилтууд 3
1.3. Арга зүй 3
1.4. Тайлангийн бүтэц 6
2. ҮНДСЭН ШИНЖ БАЙДАЛ 8
2.1. Хүн ам зүйн байдал 8
2.2. Боловсролын түвшин 10
2.3. Хөдөлмөр эрхлэлт 11
2.4. Орлого, зарлага 12
3. ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ 14
3.1. Орон байр, газар 14
3.2. Ус, ариун цэврийн байгууламж 17
3.3. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ 20
3.4. Амьжиргаа/ахуйн нөхцлийг сайжруулах талаарх санал бодол 24
4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХӨДӨЛГӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС 26
4.1. Шилжих хөдөлгөөний урсгал 26
4.2. Шилжилтийн шалтгаан, шийдвэр гаргах үйл явц 28
4.3. Шилжилтийн бэлтгэл, шилжилттэй холбоотой зардал 32
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ, СОРИЛТУУД 35
5.1. Уугуул нутагт тохиолдож буй сорилтууд 35
5.2. Шилжин суурьшсан нутагт тохиолдож буй хүндрэл бэрхшээл 37
5.3. Шилжих хөдөлгөөний бүртгэл 39
5.4. Шилжилтийн дараах өөрчлөлт, сайжралт 42
6. ИРЭЭДҮЙН ШИЛЖИЛТ 44
6.1. Ирээдүйн шилжилт 44
6.2. Буцах шилжилт 45
7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 48
7.1. Дүгнэлт 48
7.2. Зөвлөмж 50
АШИГЛАСАН МАТЕРИАЛ 53

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Шилжих хөдөлгөөний цэвэр урсгал, 2000 оноос хойш, бүс нутгаар 1
Зураг 2: Түүвэрлэлтэд хамрагдсан аймгууд 4
Зураг 3: Хүн амын суварга, нас, хүйсээр 8
Зураг 4: Насны тархалт 9
Зураг 5: Хүн ам зүйн ачаалал 9
Зураг 6: Гэрлэлтийн байдал 10
Зураг 7: Боловсролын түвшин 11
Зураг 8: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй байдал 12
Зураг 9: Сарын дундаж орлого, зарлага 13
Зураг 10: Сарын дундаж зарлага, зарлагын төрлөөр 13
Зураг 11: Ундны усны эх үүсвэр 17
Зураг 12: Усны эх үүсвэрийн байршил, дундаж зай 18
Зураг 13: Ариун цэврийн байгууламж 19
Зураг 14: Хог хаягдал зайлуулах байдал 19
Зураг 15: Шилжих хөдөлгөөний урсгал 26
Зураг 16: Одоогийн байршилд шилжиж ирснээс хойш амьдарч буй хугацаа 27
Зураг 17: Уугуул нутгаа орхин шилжсэн шалтгаан 28
Зураг 18: Шилжин суурьшсан нутгаа сонгосон шалтгаан 29
Зураг 19: Шилжилтийн шийдвэр гаргагч 31
Зураг 20: Шилжилтийн бэлтгэл 34
Зураг 21: Шилжих хөдөлгөөнтэй холбоотой зардал 34
Зураг 22: Уугуул нутагт өрхийн түвшинд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл 35
Зураг 23: Уугуул нутагт орон нутгийн түвшинд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл 36
Зураг 24: Шилжилтийн бүртгэл 40
Зураг 25: Ирээдүйд шилжихийг хүссэн газар нутаг 44
Зураг 26: Уугуул нутагтаа зарцуулж буй дундаж хугацаа 46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Дотоод шилжин суурьших хөдөлгөөн, бүс, аймаг, хотоор 5
Хүснэгт 2: Түүвэрлэлтийн хэмжээ 6
Хүснэгт 3: Сууцны төрөл (хувь) 14
Хүснэгт 4: Газар, малтай эсэх (хувь) 15
Хүснэгт 5: Цахилгаан, халаалт, хэрэглээний түлшний төрөл (хувь) 16
Хүснэгт 6: Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (хувь) 21
Хүснэгт 7: Боловсролын хүртээмж (хувь) 23
Хүснэгт 8: Амьжиргаа/ахуйн нөхцөлийг сайжруулах талаарх санал бодол (хувь) 25
Хүснэгт 9: Шилжихээс өмнө шилжин суурьших гэж байгаа газар нутгийн талаар мэдээлэл авсан байдал (хувь) 33
Хүснэгт 10: Шилжин суурьшсан нутагт тохиолдож буй хүндрэл бэрхшээл (хувь) 38
Хүснэгт 11: Шилжилт хөдөлгөөний дараа гарсан сайжралт (хувь) 43
Хүснэгт 12: Уугуул нутаг руу буцаж шилжихийг дэмжихийн тулд авах ёстой бодлогын арга хэмжээ (хувь) 47

ТҮЛХҮҮР ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТУУД

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ	
Аймаг:	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль (1993)–аар Монгол Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны 22 нэгжид хуваадаг: 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот. Аймаг, нийслэл хот бол засаг захиргааны анхан шатны нэгж юм.
Сум:	Аймаг сумдад хуваагдах ба аймгийн дараах засаг захиргааны нэгж юм.
Баг:	Сум цаашаа багт хуваагдах бөгөөд энэ нь орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгж мөн.
Дүүрэг:	Нийслэл Улаанбаатар хот 9 дүүрэгт хуваагдана. Дүүрэг нийслэлийн засаг захиргааны үндсэн нэгж юм.
Хороо:	Дүүргүүд хороодод хуваагдана. Хороо нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгж мөн.
ХОТ	
Хот:	Нийслэл Улаанбаатар болон аймгийн төвүүд “хот” гэсэн ангилалд багтана. Харин бүх сум байршлын хувьд “хөдөө” гэсэн ангилалд хамаарагдана.
ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Хүн ам зүйн ачаалал:	Энэхүү үзүүлэлт нь 15–64 насны нийт хүн амд ногдох 0–14 насны хүүхэд, 65 ба түүнээс дээш насны хүн амын харьцааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны хүн ам болоод хөдөлмөрийн бус насны хүн ам хоорондын харьцаа гэсэн үг.
Насны голч:	Энэ нь хүн амыг хоёр тэнцүү хэсэгт таллан хуваажбуй нас юм. Өөрөөр хэлбэл, тухайн хүн амын хувьд тал хувь нь энэ наснаас залуу, тал хувь нь энэ наснаас ахмад настайг илэрхийлнэ.
БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	
Боловсролгүй:	Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийг (1975–1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997–2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй хүнийг боловсролгүй гэнэ. Мөн 2018 онд ерөнхий боловсролын сургуулийн 1–6 дугаар ангид сурч байгаа ба сурч байгаад сургуулиас завсардсан хүмүүсийг боловсролгүй гэж үзнэ.
Бага боловсрол:	Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийг (1975 оныг хүртэл хуучин системээр, 1997–2004 оныг дуустал), эсвэл 1975–1996 оныг дуустал 3 дугаар ангийг, эсвэл 2005 оноос хойш 5 дугаар ангийг төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ. Мөн албан бус болон зайн сургалтыг дүүргэсэн хүмүүсийг бага боловсролтойд тооцно.
Суурь боловсрол:	Ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл), 8 дугаар ангийг (1975–2004 оныг дуустал), 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн.

Бүрэн дунд боловсрол:	Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийг (2006 он хүртэл), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй хүн.
Мэргэжил техникийн дунд:	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн. Мөн гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн.
Дээд боловсрол:	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Түүнчлэн, Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 1 жилийн курс, Марксизм–Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг энэ ангилалд хамааруулна.
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	
Ажил эрхэлдэг:	Судалгаа авах үед тогтмол хөдөлмөр эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч судалгаа авахаас өмнөх долоо хоногт ядаж нэг өдөр цалинтай ажил эрхэлсэн хүн. Энэ хугацаанд ээлжийн амралт, өвчтэй, амаржсаны амралттай байгаа хүмүүсийг ажилласанд тооцно.
Ажил эрхэлдэггүй:	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, судалгаа авахын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй, хөдөлмөр идэвхтэй хайж байгаа хүн.
ӨРХ	
Өрх:	Нэг өрх гэрт хамт амьдардаг, өрхийн нэгдсэн төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээг хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг айл өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
Өрхийн тэргүүн:	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүн гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүн нь тухайн айл өрхөд байнга оршин суугч, 16–аас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
Өрхийн гишүүд:	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг айл өрхөд хамт амьдардаг, өрхийн нэгдсэн төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээг хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн айл өрхийн гишүүн гэнэ. Гэхдээ судалгаа авах үед тухайн айл өрхийн гишүүдээс гадна айл өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ	
Огт гэрлээгүй:	Арван тав ба түнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн.
Гэрлэсэн:	Гэр бүл болсноо иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн албан ёсны баталгаатай хүн.

Хамтран амьдардаг:	Нэг гэрт ханилан суухгүйгээр хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн.
Түсгаарласан:	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр тусгаарласан гэж үзнэ.
Салсан:	Гэрлэлтээ хуулийн дагуу цуцалснаас хойш өөр хүнтэй дахин гэр бүл болж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр гэрлэлтээ цуцалсан гэж үзнэ.
Бэлэвсэн:	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойш, хугацаа харгалзахгүйгээр, өөр хүнтэй дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг бэлэвсэн гэж үзнэ.
ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН	
Шилжигч өрх:	Судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцсон, шилжих суурьшсан газар нутагтаа ядаж 180 ба түүнээс дээш хоногоор оршин сууж байгаа өрхийг “Шилжигч өрх” гэж үзнэ.
Шилжигч бус өрх:	Судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцоогүй, судалгаанд сонгогдсон уугуул нутагт оршин сууж буй өрхийг “Шилжигч бус өрх” гэж үзнэ.
УСНЫ ЭХ ҮҮСВЭР	
Ундны усны сайжруулсан эх үүсвэр:	Ундны усны сайжруулсан эх үүсвэрт төвлөрсөн, төвлөрсөн бус системд холбогдсон сууцны хоолой орно. Мөн нийтийн ус түгээх байр, гүний худаг, хамгаалагдсан энгийн худаг, хамгаалагдсан булаг, шанд, бороо, цасны ус эсвэл цэвэршүүлж савласан ус (зөвхөн цэвэршүүлж савласан усыг ундандаа хэрэглээд, ахуйн хэрэглээний усаа бусад сайжруулсан эх үүсвэрээс авдаг бол) хамаарагдана.
Ундны усны сайжруулаагүй эх үүсвэр:	Ундны усны сайжруулаагүй эх үүсвэрт хамгаалагдаагүй худаг, хамгаалагдаагүй рашаан ус, зөөврийн ус, гадаргын ус (гол мөрөн, нуур цөөрөм, булаг шанд, суваг шуудууны ус гэх мэт), савласан ус орно.
АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ	
Сайжруулсан ариун цэврийн байгууламж:	Сайжруулсан ариун цэврийн байгууламж (ус урсгаж цэвэрлэдэг жорлон буюу ус нь төвлөрсөн ариутгах систем рүү, бохирын цооног руу, нүхэн жорлон руу эсвэл тодорхойгүй газар руу урсдаг жорлон, сайжруулсан нүхэн жорлон эсвэл агааржуулалттай энгийн нүхэн жорлон)
Хамтран эзэмшдэг ариун цэврийн байгууламж:	Тодорхой түвшинд сайжруулагдсан, хоёр ба түүнээс дээш өрх хамтран эзэмшдэг, сайжруулсан ариун цэврийн байгууламж гэж бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байгууламжийг тооцно. Үүнд нийтийн нүхэн жорлон, энгийн нүхэн жорлон орно.
Сайжруулаагүй ариун цэврийн байгууламж:	Сайжруулаагүй ариун цэврийн байгууламж нь ахуйн ариун цэврийн шаардлага хангадаггүй бөгөөд ялгадас, хаягдлаа онгорхой нүх, ил задгай газар (ой мод, бут, тэгш тал газар гэх мэт) гаргахыг хэлнэ.

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсад дотоод шилжих хөдөлгөөн нь өнөөдөр ч үргэлжилсээр байгаа урт удаан түүх уламжлалтай. Сүүлийн үеийн хандлагаас харахад, хөдөөнөөс хот руу, ялангуяа, нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьшиж буй өрхүүдийн эзлэх хувь харьцангүй өндөр байгаа бөгөөд энэ нь хотжилтын түвшинг нэмэгдүүлж, хөдөөгийн уугуул нутгийн зарим хэсэгт хүн амын хэт цөөрөлтийг бий болгож байна. Шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан хот, хөдөө аль алинд хүндрэл бэрхшээлүүдийг бий болгож байгаа нь улсын бодлогын нэг гол тулгамдсан асуудал болж байна. Шилжих хөдөлгөөний судалгааг хамгийн сүүлд 2009 онд хийсэн бөгөөд түүнээс хойш энэ асуудлаар сэдэвчилсэн, нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.

Энэ судалгааны тайлан нь Монгол Улс дах дотоод шилжих хөдөлгөөний талаарх хамгийн сүүлийн үеийн тоо мэдээллийг бий болгож, дээрх мэдээллийн цоорхойг нөхөх байна. Уугуул болон шилжин суурьшсан нутгийн 1,001 өрхийн 3,715 хүн амыг хамруулан хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийгдсэн. Мөн түүнчлэн, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг статистик мэдээллийн үр дүнг батлах, гүнзгийрүүлэн тайлбарлах зорилгоор зохион байгуулан, мэдээлэл цуглуулан авсан. Ийнхүү холимог аргачлалаар судалгааг явуулснаар судалгааны үр дүн энэ чиглэлээр ажилладаг бодлого боловсруулагч нарт маш их үнэ цэнэтэй мэдээллийг өгөх учиртай.

Судалгаанд хамрагдагсдын үндсэн шинж байдлыг харвал, шилжигч бус хүн амтай харьцуулахад шилжигсэд ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насныхан байна. Мөн шилжигчдийн боловсролын түвшин өндөр байгаа нь хот суурин газар боловсрол эзэмших боломж өндөр, дээд боловсрол эзэмших шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцдог гэдгийг харуулж байна. Шилжигч болон шилжигч бус хүн амын хооронд хөдөлмөрийн зах зээлийн идэвх харилцан адилгүй байгаа нь хот, хөдөөд байгаа хөдөлмөр эрхлэх боломж, хөдөлмөрийн төрлийн ялгааг илэрхийлж байгаа хэрэг юм. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхийн энэ ялгааг эс тооцвол, өрхийн сарын дундаж орлого, зарлагын түвшин үндсэндээ адил байгаа ч хөдөөгийн шилжигч бус өрхүүдийн орлого, зарлагын түвшин хамгийн бага байна. Нөгөөтэйгүүр, шилжигч өрхүүдийн сарын орлогоо хоол хүнс, ахуйн эд зүйлс, байр сууцандаа зарцуулж буй хувь хэмжээ өндөр байна.

Ахуйн нөхцөл талаас харахад, хот, хөдөөгийн шилжигч бус өрхтэй харьцуулахад шилжигч өрхүүд орон байр, газар өмчлөх байдал бага байна. Шилжилтийн статусаас үл хамааран хотын бараг бүх өрхүүд төвлөрсөн системд холбогдсон ундны усны сайжруулсан эх үүсвэртэй байхад, хотын шилжигч өрхүүдийн дийлэнх нь дундын хамтран хэрэглэдэг ариун цэврийн байгууламж ашиглаж байна. Түүнчлэн, хөдөөгийн шилжигч бус өрхүүд эрүүл мэндийн үйлчилгээнээсээ нэлээд хол амьдарч байгаа нь хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнд тэднийг оролцоход хүргэж байна. Нөгөөтэйгүүр, хотод

шилжин суурьшсан шилжигчдийн хувьд хамгийн ойр орших дунд сургуулиас ерөнхийдөө нэлээд зайтай суурьшиж байгаа нь тэдний суурьшил хотын захад байгааг илтгэж байна.

Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн, ялангуяа, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн давамгайлж байгаа хэдий ч Сэлэнгэ, Дорноговь аймгийн хувьд хот суурин газраас хөдөө рүү чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байна. Өрхүүдийн эдийн засаг, гэр бүл, амьжиргаа/ахуйн нөхцөлөө сайжруулах хүсэл тэмүүлэл уугуул нутгаа орхин шилжих гол шалтгаан болж байна. Нөгөө талаар, шилжин суурьшсан нутгаа сонгох нь эдийн засгийн асуудлаас илүүтэйгээр гэр бүлд ойртох, нийгмийн үйлчилгээ хүртэх зэрэг шалтгаанаас ихээхэн хамаардаг байна. Шилжих шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд тухайн өрхийг тэргүүлж байгаа эсэхээс үл хамааран гол үүрэгтэйгээр оролцож байна. Шилжигчдийн шилжин суурьших нутгийн талаарх шилжихийн өмнөх мэдлэгийн түвшин хязгаарлагдмал байдаг бөгөөд, тэд ихэвчлэн гэр бүлийн бусад гишүүд, найз нөхдөөсөө энэ талаарх мэдээллийг авдаг аж. Эцэст нь, хөдөөгөөс хот руу шилжих шилжилтийн зардал бусад шилжилтийн урсгалтай харьцуулахад хамгийн өндөр байна.

Шилжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлийг харахад, шилжигч өрхүүдийн хувьд эдийн засгийн шинж чанартай хүндрэл, тэр дундаа, ажил олоход хүндрэлтэй байдаг гэсэн сорилт голлон зонхилж байна. Нөгөө талаар, шилжин суурьшсан нутагт ирснээр хүндрэл бэрхшээл нэг их тохиолдоогүй гэж шилжигч өрхийн дийлэнх олонх хариулсан боловч тэдэнд шилжин суурьшсан нутагт ирээд газрын зөвшөөрөл олдохгүй байх, байр сууцтай холбоотой багагүй бэрхшээл учирсан байна. Шилжигч өрхүүдийн хувьд, ялангуяа, Улаанбаатарт шилжилтийн бүртгэлтэй холбоотой бэрхшээл давамгайлж байгаа нь харагдлаа. Энэ нь нийслэл рүү шилжих хөдөлгөөнийг сүүлийн жилүүдэд хориглосонтой холбоотой болоод түр оршин суугчаар бүртгүүлэх сонирхол байгаа зэргээс шалтгаалж байна. Шилжигсдийн маш цөөхөн хэсэг нь шилжин ирсний дараагаар тэдний нөхцөл байдал доройтсон гэж дүгнэсэн байна.

Ирээдүйн шилжилтийн талаар сонирхоход, өрхүүдийн дийлэнх нь одоогийн суурьшсан газартаа байнга оршин суух бодолтой, цаашдаа шилжих хүсэлгүй байна. Шилжигч өрхүүд уугуул нутаг руугаа хамаатан саднаа эргэхээр тодорхой давтамжит хугацаагаар явдаг ч тэдний талаас илүү хувь бүрмөсөн буцан шилжих сонирхолгүй байна. Уугуул нутагт нь ажил эрхлэлттэй холбоотой нөхцөл байдал сайжрах юм бол шилжигч өрхүүд буцаж шилжин суурьшиж болно гэж үзэж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн бодлогын дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. Дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг хөгжлийн төлөвлөлт, салбар, салбар дундын бодлогод тусгах.
2. Шилжигч хүн амыг нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрт хамруулах.
3. Шилжигчдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах.
4. Буцах шилжилтийг дэмжихийн тулд уугуул нутгийн ахуйн орчин нөхцөлийг сайжруулах.
5. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг арилгахын тулд тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн бодлого боловсруулах.
6. Шилжих хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах, дэмжих.
7. Шилжигч болон шилжигч бус хүн амын хооронд нийгмийн нэгдмэл байдлыг дэмжих зорилгоор, шилжигчдэд тулгарч буй сорилт, бэрхшээлийг даван туулахад нь туслах, үүднээс мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах, нэмэгдүүлэх.
8. Баримт нотолгоонд суурилсан бодлого боловсруулахын тулд шилжих хөдөлгөөний судалгааг үндэсний хэмжээнд, тодорхой цаг хугацааны давтамжтайгаар зохион байгуулах.

1. УДИРТГАЛ

1.1. Үндэслэл

Монголчууд түүхийн туршид нүүдлийн амьдралыг чухалчилж ирсэн тул дотоод шилжих хөдөлгөөн нэг их гайхаад байхаар шинэхэн сэдэв биш юм. Түхайлбал, 1990–ээд оны эхээр Зөвлөлт холбоот улс задарч, зах зээлийн эдийн засагт шилжсэн нь хүмүүс олноороо шинээр тунхаглагдсан эрхийнхээ дагуу хөдөөд ажил эрхлэх, ялангуяа, мал маллах зорилгоор шилжилтэд оролцсон нь хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөнд ихээхэн нөлөөлсөн (Guinness and Guinness, 2012). Гэвч сүүлийн жилүүдэд шилжилтийн урсгал зарчмын хувьд өөрчлөгдөж, хөдөөгөөс хот руу, тэр дундаа, нийслэл Улаанбаатар руу чиглэх болсон. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)–ны албан ёсны мэдээллээр, шинэ зуун гарсаар жилд дунджаар 103,000 монголчууд дотоод шилжилтэд оролцсон байна (ҮСХ, 2017).

Монгол Улс доторх дотоод шилжих хөдөлгөөн нэг төрлийн биш бөгөөд газар зүйн бүс нутгуудын зарим нь хүнээ алдаж байхад зарим нь олон тооны хүн хүлээн авсаар байна. Зураг 1–д 2000 оноос хойшхи хүн амын дотоод шилжих цэвэр хөдөлгөөн (шилжин ирсэн хүн амаас шилжин явсан хүмүүсийг хассан зөрүү)–ийг таван бүсээр (нийслэл Улаанбаатарыг оруулснаар) харуулав. Энэ хугацаанд Улаанбаатар дотоод шилжигчдийг татдаг хамгийн гол бүс нутаг гэдэг нь харагдаж байгаа бөгөөд жилд дунджаар 21,000 орчим цэвэр шилжилттэй байна. Нөгөө талаас, Баруун бүс энэхүү хугацаанд хамгийн их хүнээ алдсан байгаа ба цэвэр шилжилтийн хэмжээ жилд дунджаар 8,000 байна. Сонирхолтой нь, нийслэл руу шилжин ирэх хөдөлгөөнийг хориглосноос болж 2017 онд Улаанбаатарын хувьд шилжилтийн хандлага өөрчлөгдсөн байна. Энэ хориг нь нийслэл рүү шилжин ирэх хөдөлгөөнийг бууруулахад хүргэсэн төдийгүй албан ёсны статистик бүртгэлд бүртгүүлээгүй шилжигчдийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна. Зураг 1 нь Монголын дотоод шилжих хөдөлгөөнийг ойлгох үндсэн мэдээллийг бидэнд өгөх боловч уугуул нутгаа яагаад орхих болсон шалтгаан, шилжин суурьшсан нутагт тэдний нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн талаарх бүрэн дүр зургийг харуулж чадахгүй.

Зураг 1: Шилжих хөдөлгөөний цэвэр урсгал, 2000 оноос хойш, бүс нутгаар



Шилжигчдийг уугуул нутгаа орхих эсвэл шилжин суурьшсан нутгийг сонгоход хүргэсэн олон суурь шалтгаан байж магадгүй. Хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал, амьдрах нөхцөл муу, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар хангалтгүй зэргээс болж уугуул нутгаа орхиход хүрдэг. Монгол улсад хийгдсэн өмнөх судалгаанууд ч гэсэн хот суурин газар, тэр дундаа, нийслэл хотод шилжин ирэгчид дээр дурьдсан нөхцөл байдал, боломжоо сайжруулахын тулд шилжилтэд оролцсон гэдгийг харуулсан байдаг.[1] Өнөөдрийн байдлаар дээрх суурь шалтгаанууд шилжих хөдөлгөөнийг хөдөлгөгч хүч хэвээр байгаа боловч бүс нутгийн онцлог, өөрчлөлттэй эдгээр нь хэрхэн холбоотой байгаа талаар төдийлөн судлагдаагүй байна.

Хот, хөдөөгийн аль ч бүс нутгийн хувьд дотоод шилжих хөдөлгөөнөөс шалтгаалсан хүндрэл, сорилтууд тулгарч, энэ нь улсын бодлогын нэг гол тулгамдсан асуудал болж байна. Тухайлбал, Улаанбаатар руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нь нийгмийн үйлчилгээнд, тэр дундаа, хотын гэр хорооолд ихээхэн дарамт, ачаалал авчрахын зэрэгцээ агаар, ус, хөрсний бохирдлыг нэмэгдүүлж, газрын зүй бус ашиглалт руу чиглүүлэн, ядуурал, ажилгүйдлийн түвшинд хувь нэмэр оруулж байна. Нөгөө талаас, хөдөө нутагт сөрөг үр дагавар, тухайлбал, орон нутаг эзгүйрэх, цөлжих, хүний нөөцөө алдахад хүргэж байна. Эдгээр тулгамдсан асуудал, сорилтуудыг шийдвэрлэхийн тулд дотоод шилжих хөдөлгөөний мөн чанарыг харуулсан тоо мэдээлэл, шилжин суурьшигчдыг татаж буй хүчин зүйлс, шилжилтийн эхний байршлаа сонгох болсон шалтгаан зэргийг сайн судлах хэрэгтэй байна.

Дотоод шилжих хөдөлгөөний судалгааг хамгийн сүүлд 2009[2] онд хийсэн бөгөөд үүнээс хойш энэ талаар сэдэвчилсэн судалгаа хийгдээгүй, нарийвчилсан мэдээлэл ихээхэн хомс байна. ҮСХ 2015 онд Хүн амын завсрын тооллого хийж, дотоод шилжих хөдөлгөөний ерөнхий хандлага, урсгалын талаарх мэдээллийг цуглуулсан байна. Гэвч шилжих хөдөлгөөний шалтгаан, уугуул болон шилжин суурьшсан нутаг дахь хөдөлгөгч хүчин зүйлс, шилжих хөдөлгөөнтэй холбоотой сорилтууд, шилжилтийн шийдвэр гаргалт болон шилжих хөдөлгөөнтэй холбоотой бусад зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулагдаагүй байна. Түүнчлэн, сүүлийн үеийн статистик мэдээлэлд суурилсан дотоод шилжих хөдөлгөөний бодлого дутмаг, шилжих хөдөлгөөнийг зохицуулж буй төр засгийн арга хэмжээ тодорхой бус, бүртгэлийн хангалтгүй байдал, газрын зөвшөөрөл, агаарын бохирдол, эрүүл ахуйн дорой байдал зэргийг шийдвэрлэх хэрэгцээ байсаар байна.

Ийм учраас судалгааны багийнхан хамгийн сүүлийн үеийн дотоод шилжих хөдөлгөөний мэдээллээр бодлого боловсруулагч нарыг хангахын тулд шилжих хөдөлгөөний талаар өрхийн цогц судалгааг хийлээ. Судалгааг Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)–ын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг ойлгож, зохицуулах нь” төслийн хүрээнд, Монгол улсын их сургуулийн Хүн амын сургалт судалгааны төв (ХАССТ)–ийн судалгааны баг хийж гүйцэтгэв.

1 ХАССТ, 2001; ХАССТ, 2005; ХАССТ, 2010; АШУИС, 2007; ҮСХ, 2007.
2 ХАССТ, 2010.

1.2. Зорилго, зорилтууд

Судалгаа нь Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг ойлгох, тодорхойлох зорилготой бөгөөд дараах сэдвийн хүрээнд хийгдсэн. Үүнд:

Дээрх сэдвийн хүрээнд судалгааны дараах гол асуултад хариулт өгөхийг зорьсон. Үүнд:

1. Шилжигч болон шилжигч бус өрхийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж байдал ямар байна вэ?
2. Хөдөөгийн оршин суугчдыг хот суурин газар руу шилжих шийдвэрт хүргэж бүй уугуул нутгийн өдөөгч, түлхэх хүчин зүйлс юу вэ?
3. Хотын оршин суугчдыг хот суурин газар руу шилжих шийдвэрт хүргэж бүй уугуул нутгийн өдөөгч, түлхэх хүчин зүйлс юу вэ?
4. Хувь хүн, өрх, хэсэг бүлгийн хувьд ямар "үйл явдал", нөхцөл байдал хүмүүсийг шилжих шийдвэр гаргахаас өөр гарцаагүй байдалд хүргэсэн вэ?
5. Шилжих хөдөлгөөнд оролцсон өрх шилжихээсээ өмнө болон шилжсэнийхээ дараа ямар хүндрэл бэрхшээл, сорилттой тулгарч байна вэ?
6. Шилжих хөдөлгөөнд хэрхэн бэлтгэж байна вэ?
7. Шилжилтийн эцсийн зогсоол буюу шилжин суурьшиж бүй нутгаа хэрхэн сонгож байна вэ?
8. Шилжигчид шилжих хөдөлгөөн оролцохоосоо өмнө шилжин суурьших нутгийнхаа талаар ямар ойлголт, төсөөлөлтэй байна вэ?
9. Шилжигчид уугуул нутгийнхаа талаар ямар төсөөлөлтэй байна вэ?

Дээрх асуултуудад хариулт авахын тулд тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулан хэрэглэсэн бөгөөд ингэснээр асуудлыг илүү тодорхой болгож чадсан. Тоон судалгааны аргачлалыг судалгааны үндсэн асуултуудад хариулахын тулд ашигласан бол чанарын судалгааг тоон судалгааны үр дүнг илүү нарийвчлан, гүнзгийрүүлэн тайлбар, дүгнэлт хийхэд хэрэглэсэн.

1.3. Арга зүй

Монгол Улс нь эдийн засгийн бүсчлэлийн хувьд газар зүйн таван бүсэд, тухайлбал, Баруун, Хангай, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсэд хуваагддаг. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль (1993 он)–ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны 22 анхдагч нэгжид, өөрөөр хэлбэл 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот гэж хуваадаг. Аймгуудсумдад, Улаанбаатар хот дүүргүүдэд хуваагдана. Сумд багт, дүүргүүд хороонд

хуваагдах ба тэдгээр нь засаг захиргааны анхан шатны нэгж болно.

Зураг 2: Түүвэрлэлтэд хамрагдсан аймгууд

Эх сурвалж: Монгол Улсын Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)–ын GIS мэдээллээс авав.

Энэхүү газрын зургийг зөвхөн үзүүлэнд зориулсан тул зурагт өгөгдсөн хил болон нэр нь Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллагаар албан ёсоор баталгаажаагүй болно.

Өрхийн судалгаанд хамрагдсан газруудыг ҮСХ–ны 2010–2016 оны дотоод шилжих хөдөлгөөний мэдээлэлд үндэслэн сонгосон бөгөөд үүнийг Хүснэгт 1–д үзүүлэв. Тодруулбал, аймгуудыг хоёр ангилалд, “уугуул нутаг”, “шилжин суурьшсан нутаг” гэж хуваасан бөгөөд шилжилтийн нийт хэмжээ, цэвэр шилжилтийн түвшин зэргийг харгалзан үзсэн болно. Зураг 2–т түүвэрлэлтэд сонгогдсон аймгуудыг харууллаа. Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатар хот шилжин суурьшсан нутагт, Баруун, Хангайн, Зүүн бүсүүд уугуул нутагт ангилагдсан болно.

Олон шатат, санамсаргүй түүврийн аргыг түүвэрлэлтэд ашигласан ба түүврийг 4 үе шаттайгаар гүйцэтгэсэн. Нэгдүгээрт, шилжин явалт хамгийн ихтэй гурван аймаг, тухайлбал, Увс (Баруун бүс), Баянхонгор (Хангайн бүс), Сүхбаатар (Зүүн бүс) аймгууд “уугуул нутаг”–аас судалгаанд сонгогдсон. Бусад аймгуудтай харьцуулахад хамгийн их шилжин ирэлт ихтэй байсан учраас Сэлэнгэ, Дорноговь аймгууд “шилжин суурьшсан нутаг”–аас, Улаанбаатар хамгийн их шилжин ирэлт ихтэй бүс гэдгээрээ тус тус шилжин суурьшсан нутаг хэмээн судалгаанд сонгогдсон. Хоёрдугаарт, сонгогдсон аймаг бүрээс тус бүр 2 сумыг судалгаанд хамруулахаар сонгосон. Нэг сум нь аймгийн төвийнх, нөгөө сум нь хөдөөгийнх боловч тухайн аймаг дотроо бусад сумдынхаа хүн амтай харьцуулахад хүн амын тоогоороо харьцангуй дундаж байх шаардлагыг хангасан сум байхаар сонгон авсан. Улаанбаатар хотын 9 дүүргээс хамгийн их цэвэр шилжих хөдөлгөөн ихтэй Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг сонгосон. Гуравдугаарт, сонгогдсон сум, хороо тус бүрээс 2 багийг санамсаргүй

байдлаар сонгосон бөгөөд сумын хувьд нэг баг нь сумын төвийнх байхаар тус тус сонголтыг хийсэн. Ийнхүү нийт судалгаанд 20 баг, 10 хороо сонгогдсон. Дөрөвдүгээрт, тухайн сонгогдсон баг/хорооны хүн ам, өрхийн мэдээллийн санд үндэслэн судалгааны үндсэн нэгж болох "өрх"–ийг санамсаргүй түүврээр сонгон авсан. Судалгаанд баг бүрээс 30 өрх, хороо бүрээс 40 өрхийг шилжилтийн статусыг харгалзан, санамсаргүй түүврийг аргаар сонгосон. Нийтдээ судалгаанд 1,000 өрх сонгогдсон ч мэдээлэл цуглуулах үеэр үл ялиг илүү өрхийг судалгаандаа хамруулсан. Хүснэгт 2–оор судалгааны түүврийн үе шат бүрийг харууллаа.

Хүснэгт 1: Дотоод шилжин суурьших хөдөлгөөн, бүс, аймаг, хотоор

Бүс	2010–2016		Цэвэр шилжилт	Газар нутгийн ангилал
	Шилжин ирэлт	Шилжин явалт		
БАРУУН	**22,798**	**67,256**	**–44,458**	
Баян–Өлгий	1,242	9,604	–8,362	Уугуул нутаг
Говь–Алтай	3,002	10,890	–7,888	Уугуул нутаг
Завхан	6,488	17,352	–10,864	Уугуул нутаг
Увс	4,709	14,318	–9,609	Уугуул нутаг
Ховд	7,357	15,092	–7,735	Уугуул нутаг
ХАНГАЙН	**47,302**	**94,345**	**–47,043**	
Архангай	4,585	13,813	–9,228	Уугуул нутаг
Баянхонгор	4,375	11,658	–7,283	Уугуул нутаг
Булган	8,286	11,564	–3,278	Уугуул нутаг
Орхон	18,750	24,424	–5,674	Шилжин суурьшсан нутаг
Өвөрхангай	5,291	18,276	–12,985	Уугуул нутаг
Хөвсгөл	6,015	14,610	–8,595	Уугуул нутаг
ТӨВИЙН	**85,293**	**101,682**	**–16,389**	
Говьсүмбэр	5,398	4,570	828	Шилжин суурьшсан нутаг
Дархан–Уул	19,304	24,375	–5,071	Шилжин суурьшсан нутаг
Дорноговь	10,495	10,525	–30	Шилжин суурьшсан нутаг
Дундговь	4,278	10,484	–6,206	Уугуул нутаг
Өмнөговь	9,767	6,794	2,973	Шилжин суурьшсан нутаг
Сэлэнгэ	20,158	22,912	–2,754	Шилжин суурьшсан нутаг
Төв	15,893	22,022	–6,129	Шилжин суурьшсан нутаг
ЗҮҮН	**19,359**	**32,529**	**–13,170**	
Дорнод	5,342	10,889	–5,547	Уугуул нутаг
Сүхбаатар	4,612	7,237	–2,625	Уугуул нутаг
Хэнтий	9,405	14,403	–4,998	Уугуул нутаг
УЛААНБААТАР	**207,772**	**81,629**	**126,143**	
Улаанбаатар	207,772	81,629	126,143	Шилжин суурьшсан нутаг

Эх сурвалж: ҮСХ, 2017.

Судалгааны анхдагч нэгж нь “өрх” бөгөөд өрхийн гишүүн нэг бүрийн мэдээллийг судалгааны асуулгад хариулагч гол этгээд өгсөн болно. Судалгааны зорилгын хүрээнд уугуул болон шилжин суурьшсан нутгаас шилжигч, шилжигч бус өрхийг сонгон судалгаанд хамруулсан. Судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцсон, шилжин суурьшсан газар нутагтаа ядаж 180 ба түүнээс олон хоногоор оршин сууж байгаа өрхийг “Шилжигч өрх” гэж үзсэн. Судалгаанд 1,001 өрх (шилжигч бус 360 өрх, шилжигч 641 өрх)–ийн 3,715 хүн амыг хамруулсан.

Хүснэгт 2: Түүвэрлэлтийн хэмжээ

Аймаг/хот	**Сум/дүүрэг**	**Сонгогдсон:**		**Хамрагдсан:**
		Баг/хорооны тоо	**Баг/хороо бүрээс сонгогдсон өрхийн тоо**	**Нийт өрхийн тоо**
Уугуул нутаг				
1. Увс	1. Тэс	2	30	60
	2. Улаангом	2	30	60
2. Баянхонгор	1. Эрдэнэцогт	2	30	60
	2. Баянхонгор	2	30	60
3. Сүхбаатар	1. Уулбаян	2	30	60
	2. Баруун–Урт	2	30	60
Шилжин суурьшсан нутаг				
1. Дорноговь	1. Замын–Үүд	2	30	60
	2. Сайншанд	2	30	60
2. Сэлэнгэ	1. Баянгол	2	30	60
	2. Сүхбаатар	2	30	60
3. Улаанбаатар	1. Баянзүрх	5	40	200
	2. Сонгинохайрхан	5	40	201
БҮГД		20/10	600/400	1,001

Өрхийн судалгаанаас гадна, сонгогдсон баг, хороо бүрээс шилжигч болон шилжигч бус өрхийн 8–10 хүнийг оролцуулсан бүлгийн ярилцлага зохион байгуулан, мэдээлэл цуглуулсан. Орон нутагт иргэний бүртгэл мэдээлэл хариуцсан болон бусад холбогдох мэргэжилтэн, албан хаагчдаас ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан. Ярилцлагад сонгогдсон баг, хороо бүрээс хоёр бүлэг хамрагдсан ба нэг нь өрхийн төлөөлөл, нөгөө нь орон нутгийн засаг захиргааны удирдлага, албан тушаалтнуудын төлөөлөл байв.

1.4. Тайлангийн бүтэц

Судалгаа нь Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн дүр төрх, нөхцөл байдлыг сайтар ойлгох, тодорхойлох хүрээнд судалгаанд хамрагдсан түүвэр өрх, хүн амын хувьд хандлагыг дүрслэн харуулахыг зорьсон. Судалгааны сэдэв, үндсэн асуултуудад хариулахын тулд цуглуулагдсан мэдээллийг шилжигч, шилжигч бус өрх, шилжих хөдөлгөөний 4 урсгалаар, тухайлбал, хөдөө–хот, хөдөө–хөдөө, хот–хот, хот–хөдөө гэсэн ангиллаар шилжигч өрхийг

ангилан дүн шинжилгээ хийв. Үүнээс гадна, хот, хөдөөгийн байршлаар болон эрэгтэй, эмэгтэй хүйсийн ялгавартай байдлаар зарим шаардлагатай хэсгүүдэд харьцуулалтыг хийсэн. Тухайн өгүүлбэр бүрийг догол шинэ мөрнөөс эхлэхдээ түлхүүр мэдээллийг тодруулан харуулахыг зорьсон бөгөөд энэ нь судалгааны үр дүнг товч ойлгомжтойгоор унших боломжийг олгож байгаа юм.

Судалгааны тайлан нь удиртгал бүлгийг оруулан 7 бүлэг, ашигласан материалаас бүрдэнэ. Бүлэг 2 судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн үндсэн шинж байдлын мэдээллийг дэлгэрэнгүй өгүүлэх бол Бүлэг 3 өрхийн ахуйн нөхцөлийн тухай танилцуулна. Шилжигч өрхийг тусгайлан анхаарсан бөгөөд Бүлэг 4–өөр дотоод шилжих хөдөлгөөний урсгал, шилжилтийн шалтгаан болон шилжилт хийхтэй холбоотой бусад холбогдох хүчин зүйлсийн талаар өгүүлнэ. Бүлэг 5 уугуул болон шилжин суурьшсан нутагт шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор тохиолдож буй хүндрэл бэрхшээл, сорилтууд, шилжсэний дараа бий болсон сэтгэл ханамж, бүртгэлийн асуудлыг шинжлэн харуулна. Бүлэг 6 ирээдүйн шилжилтэд чиглэгдсэн бөгөөд уугуул нутаг руугаа буцах шилжилт бий эсэх талаарх зарим мэдээллийг харуулна. Эцэст нь Бүлэг 7 судалгааны үр дүнд суурилсан дүгнэлт, зөвлөмжийг танилцуулна.

2. ҮНДСЭН ШИНЖ БАЙДАЛ

2.1. Хүн ам зүйн байдал

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын бүтэц нь Монгол Улсын нийт хүн амын насны бүтэцтэй бараг адилхан байна. Зураг 3–аар хүн амын нас–хүйсийн бүтцийн суваргыг 5 насны бүлгээр харуулав. Судалгаанд хамрагдсан хүн амын 48% эрэгтэй, 52% эмэгтэй. Хүйсийн харьцаа 0.91 байгаа ба 2015 оны тооллогын мэдээллээр нийт хүн амын хүйсийн харьцаа 0.97 байгаа нь харьцуулагдахуйц харагдаж байна (ҮСХ, 2016). Судалгаанд хамрагдсан хүн амын насны голч 25 жил байгаа нь албан ёсны статистик мэдээллээр нийт хүн амын насны голч 28 жил байгаатай ойролцоо байна.

Зураг 3: Хүн амын суварга, нас, хүйсээр



Шилжигчдийн насны бүтцийн тархалтыг ажиглахад тэд ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насны хүн ам байна. Зураг 4–т судалгаанд түүвэрлэгдсэн хүн амын нас–хүйсийн бүтцийг шилжилтийн статусаар буюу шилжигч, шилжигч бус гэсэн ангиллаар харууллаа. Шилжигч бус хүн амын насны бүх бүлэгт онц ялгаа байхгүй байхад 25–29 насны бүлэгт шилжигчдийн эзлэх хувийн жин огцом өсч 35–39 насны бүлгийн шилжигч бус хүн амын хувийн жингээс илүү өндөр байна. Түүнчлэн, 0–4 насны шилжигч хүүхдүүдийн эзлэх хувийн жин нь шилжигч бус хүүхдүүдээс 6 хувиар өндөр байгаа нь бага насны хүүхдүүдтэй өрх шилжин суурьшиж байгааг илтгэнэ. Ерөнхийдөө, шилжин суурьшиж байгаа өрхийн хүн амын дийлэнх хувийг 25–39 насны залуучууд, 10 ба түүнээс доош насны хүүхдүүд эзэлж байна. Хүйсийн хувьд 20–24 насны эмэгтэйчүүдийн дунд мөн насны эрчүүдийг бодвол шилжин суурьших нь илүү өндөр байгаа нь эмэгтэйчүүдийн их дээд сургуульд суралцах, бага насны хүүхэдтэй эхчүүд эр нөхрөө дагаж дотоод шилжих хөдөлгөөнд оролцдогийг харуулж байна.

Зураг 4: Насны тархалт

Шилжигч өрхийн хүн амын ачаалал харьцангуй өндөр байгаа нь тэд өрхийн бусад гишүүд, хүүхдүүдийг тэжээн тэтгэдэг гэдгийг харуулж байна. 0–14 насны хүүхэд, 65–аас дээш насны хүнийг тэжээлгэгч гэж үзвэл, шилжигч өрхийн хүн ам зүйн ачаалал нь шилжигч бус өрхөөс даруй 13 хувиар өндөр байгааг Зураг 5–д харуулжээ. Өөрөөр хэлбэл, шилжигч бус өрхийн хөдөлмөрийн насны 10 хүнд 6–аас доош тэжээлгэгч ногдож байхад шилжигч өрхийн 10 хүн тутамд бараг 7 тэжээлгэгч ногдож байна гэсэн үг. Хүүхэд болон ахмад настны ачааллаар харвал, шилжигч өрхийн хүүхэд насны хүн амын ачаалал илүү өндөр байгаа нь тодорхой харагдана.

Зураг 5: Хүн ам зүйн ачаалал



Тэмдэглэл: Хүн ам зүйн ачаалал гэдэг бол хүүхэд насны (0–14 нас) хүн амын тоон дээр ахмад насны (65–аас дээш) хүн амын тоог нэмээд хөдөлмөрийн насны (15–64 насны хооронд) хүн амын тоонд харьцуулсан харьцаа юм.

Судалгаанд хамрагдсан хүн амын дийлэнх нь гэрлэсэн болон хамтран амьдрагчтай байгаа болов энэ үзүүлэлт шилжигч, шилжигч бус хүн амын хооронд мэдэгдэхүйц ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс

дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг Зураг 6–д харуулж байна. Хоёр бүлэг хүн амын ихэнх нь хамтран амьдрагчтай байна. Шилжигч бус хүн амтай харьцуулахад, шилжигсэд илүү залуу насныхан байсан учраас тэдний дунд гэрлэсэн хүн ам харьцангуй цөөхөн байна (42% ба 58%). Харин эсрэгээрээ, хамтран амьдрагчтай шилжигсдийн хувь бараг 4 дахин өндөр байна (25% ба 6%).

Зураг 6: Гэрлэлтийн байдал



Тэмдэглэл: Гэрлэлтийн байдлыг 15 ба түүнээс дээш насны судалгаанд хамрагдсан хүн амаас асуусан. “Бусад” гэсэн ангилалд тусгаарласан, салсан, бэлэвсэн гэсэн хүмүүс багтаж байна.

2.2. Боловсролын түвшин

Шилжигч бус хүн амтай харьцуулахад шилжигсдийн боловсролын түвшин дунджаар өндөр байгаа нь залуучууд сурч боловсрох боломжоор илүүтэйгээс гадна их дээд боловсрол эзэмшихээр шилжих хөдөлгөөнд илүү оролцож байгааг харуулж байна. Зураг 7–д 6 ба түүнээс дээш насны хүн амын эзэмшсэн боловсролын түвшинг харуулав. Шилжигсдийн 38 орчим хувь наад зах нь бүрэн дунд боловсролтой байгаа бол тэдний 23% нь дээд боловсролтой, түүний дотор бакалавр, магистрын зэрэгтэй хүмүүс байна. Энэ тоо баримт нь шилжигчдийн дийлэнх залуу насны хүн ам байгаа учир тэд ахмад настай хүмүүстэй харьцуулахад, боловсрол эзэмших боломжоор илүү, мөн мэргэжил үйлдвэрлэл, их дээд сургуульд суралцахын тулд шилжилтэд оролцдог гэдгийг нотолж байна. Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 15 орчим хувь нь ямар нэг сургуульд сурч байгаагүй ба хоёр бүлгийн хооронд онцын ялгаагүй байна.

Хүйсийн хувьд, эмэгтэйчүүд илүү өндөр боловсрол эзэмшсэн байна. Тодруулбал, нийт эмэгтэйчүүдийн 23% нь бакалавр, магистрын зэрэгтэй байгаа бол эрчүүдийн хувьд энэ үзүүлэлт нь 17% байна. Цаашилбал, шилжигч эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нь шилжигч бус эмэгтэйчүүдээс өндөр байна, үүний нэгэн адил шилжигч эрчүүдийн боловсролын түвшин нь шилжигч бус эрчүүдээс өндөр байна.

Зураг 7: Боловсролын түвшин



Тэмдэглэл: Боловсролын түвшин зөвхөн 6 ба түүнээс дээш насны хүнд хамааралтай. ‘Дээд боловсрол’–д бакалавр, магистрын зэрэг хамгаалсан хүмүүсийг оруулсан.

2.3. Хөдөлмөр эрхлэлт

Хот, хөдөөд хөдөлмөр эрхлэх боломж, ажлын төрлөөс хамааран шилжигч болон шилжигч бус хүн амын дунд хөдөлмөрийн зах зээл дээрх идэвх ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан нийт хүн амын тал гаруй хувь нь судалгаанд хамрагдахын өмнөх долоо хоногт ямар нэг төрлийн хөдөлмөр эрхэлж байсан ба шилжигчдийн дунд шилжигч бус хүн амтай харьцуулахад 5 хувиар бага байна (тус бүр 47%, 52%). Судалгааны өмнөх долоо хоногт хөдөлмөр эрхэлсэн хүн амын хөдөлмөрийн зах зээлийн идэвхийг хот, хөдөөгийн байршлын ялгаатай байдлаар Зураг 8–д харуулав. Хот, хөдөөд шилжигчдийн хувьд цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлт шилжигч бус хүн амтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа бол хөдөөд энэ ялгаа хоёр бүлгийн хувьд мэдэгдэхүйц өндөр байна. Нөгөөтэйгүүр, хөдөөгийн шилжигч бус хүн амын талаас илүү хувь нь мал маллаж, газар тариалан эрхэлж байна. Үүнийг боловсролын түвшинтэй уялдуулан харвал, боловсролтой хүн ам хот суурин газар ихэвчлэн суурьшин, цалин хөлстэй ажил эрхэлж байгаа бол хөдөөд ийм ажлын байр хомс гэдгийг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүн амын дийлэнх олонх нь ажил идэвхтэй хайхгүй байна. Судалгаа хийхийн өмнөх долоо хоногт судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн 70 гаруй хувь нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй хүн ам байжээ, өөрөөр хэлбэл, ийм хүмүүсийн тоонд суралцагчид, тэтгэвэрт гарсан хүмүүс, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хүүхэд болон гэр бүлийн өвчтэй бусад гишүүнийг асран халамжилж байсан хүмүүс багтаж байна. Шилжигч бус хүн амтай харьцуулбал шилжигчид хүүхэд харах, гэр бүлийн бусад гишүүнийг асран халамжлах шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байгаа хувийн жин нь илүү байна (тус бүр 10% ба 27%). Хөдөлмөр эрхлээгүй

хүн амын зөвхөн дөрөвний нэг орчим хөдөлмөрийн зах зээл дээр идэвхтэй байгаа нь тэдэнд тохирсон ажил олдохгүй байгааг илэрхийлж байна. Энэ үзүүлэлт нь шилжигч хүн амын дунд шилжигч бус хүн амаас маш доогуур буюу тус бүр 19%, 31% байна.

Гэр бүлийн гишүүдээ асран халамжилж байгаа хүн амын хувьд хүйсийн ялгаа мэдэгдэхүйц байна. Хөдөлмөр эрхлээгүй гурван эмэгтэйгээс нэг нь хүүхэд харах эсвэл өрхийн хэн нэг гишүүнийг асран халамжилж байгаа бол энэ үзүүлэлт нь эрчүүдийн хувьд ердөө 4% байна. Үүний нэгэн адил, шилжигч эрчүүдийг бодвол эмэгтэйчүүд энэ үзүүлэлтээр өндөр байна (41%, 16%).

Зураг 8: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй байдал



Тэмдэглэл: хөдөлмөрийн зах зээлийн идэвх зөвхөн 15 ба түүнээс дээш насны хүмүүст хамааралтай.

2.4. Орлого, зарлага

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхийн ялгаанаас гадна, шилжигч болон шилжигч бус өрх хоорондын сарын дундаж орлого, зарлагын түвшин ихээхэн ялгаатай байна. Хөдөөгийн шилжигч бус өрхийн хувьд орлого, зарлагын түвшин хамгийн бага байна. Зураг 9 хот, хөдөө дэх шилжигч болон шилжигч бус өрхийн сарын дундаж орлого, зарлагыг харуулж байна. Хотын шилжигч бус өрхийн орлого шилжигч өрхийнхөөс 60,000 төгрөг (буюу 25 ам.доллар)–өөр илүү байна. Нөгөөтэйгүүр, шилжигчдийн дундаж зарлага мөн ийм хэмжээгээр илүү байгаа ба энэ нь тэдэнд хадгаламж хийх боломж байхгүйг харуулж байна. Хөдөөгийн шилжигч өрхийн хувьд сарын дундаж орлого хотын шилжигчдээс илүү, зарлага нь бараг 50,000 төгрөг (20 ам.доллар)–өөр бага байна. Хөдөөгийн шилжигч бус өрхийн сарын дундаж орлого, зарлага хамгийн бага байгаа бөгөөд энэ нь тэдний мал аж ахуй эрхэлж буйтай холбоотой юм.

Зураг 9: Сарын дундаж орлого, зарлага



Шилжигч өрхүүд сарын дундаж орлогынхоо ихэнх хувийг хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа, орон байрандаа зарцуулж байна. Зураг 10–д сарын зарлага, зарлагын төрлөөр харуулж байна. Хот хөдөөгийн шилжигч болон шилжигч бус өрхүүдийг харьцуулбал, шилжин суурьшсан өрхүүд сарынхаа орлогын ихэнх хувийг хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа, орон байранд зарцуулдаг байна. Түүнээс гадна, хот суурин газарт шилжин суурьшсан байдлаас үл хамааран хотын оршин суугчдын зарлагын дийлэнх хувийг орон байрны зардал эзэлж байна.

Зураг 10: Сарын дундаж зарлага, зарлагын төрлөөр



3. ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ

3.1. Орон байр, газар

Монголчуудын уламжлалт сууц монгол гэр нийт хүн амын зонхилох сууцны төрөлд багтаж байгаа ч хөдөө орон нутагт шилжин суурьшигч өрхүүдийн илүү өндөр хувь нь байшинд амьдарч байна. Хүснэгт 3–аар хот, хөдөөгийн шилжигч, шилжигч бус өрхийн сууцны төрлийг харуулав. Хөдөө орон нутагт хоёр бүлгийн хүн ам монгол гэрт адилхан амьдардаг байж болох боловч, монгол гэрт амьдарч байгаа шилжигч бус өрхүүдийн эзлэх хувь нь харьцангүй өндөр байна. Нөгөө талаас, хөдөөгийн шилжигч өрхүүд байшинд, тодруулбал, орон сууцны байшин эсвэл бие даасан сууцанд амьдрах нь илүү байна. Хот суурин газарт сууцны төрөлд төдий л мэдэгдэхүйц ялгаа байхгүй, учир нь хотын хүн амын бараг тал хувь монгол гэрт, нөгөө хэсэг нь орон сууцны байшинд амьдардаг байна. Орон байр, сайн сайхан аж байдал хоёр салшгүй холбоотойг харгалзан үзвэл, монгол гэр нь төвлөрсөн халаалт, усан хангамж, бохирын нэгдсэн шугамд холбогдоогүй байдгийг онцлох нь зүйтэй болов уу. Нөгөө талаар, “гэр” сууц нь байр сууцны төрлийн хязгаарлагдмал төрөл боловч хөдөөд орон сууцны нийлүүлэлт хангалтгүй бага, хот сууринд, ялангуяа, Улаанбаатар хотод орон сууцны үнэ харьцангүй өндөр байна.

Шилжигч өрхүүд хот, хөдөө ялгаагүй байр сууцаа өмчлөх байдал бага байна. Хүснэгт 3 хот, хөдөөгийн байршлаар шилжигч, шилжигч бус өрхийн сууцны эзэмшлийн талаар нэлээд ялгавартай байдал байгааг харуулсан байна. Ялгаатай байдал ялангуяа, хөдөөд их буюу шилжигч өрхтэй харьцуулахад шилжигч бус өрхийн сууц өмчлөлийн түвшин 41 хувиар өндөр байна. Энэ хандлага шилжигч өрхүүдийн орлого хязгаарлагдмал, хадгаламж бага учир гэр, орон сууц эсвэл ямар төрлийн сууц байхаас үл хамааран ижил байна. Магадгүй энэ нь шилжигч өрхүүдийн шинэ газар нутагт ирэхдээ оршин суух зөвшөөрөл аваагүй, түүнийг авахад ямар үйл явц, мэдээлэл шаардлагатай байдгийг мэдэхгүйтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт 3: Сууцны төрөл (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Сууцны төрөл				
Монгол гэр	75.6	43.8	54.4	53.5
Байшин	23.9	55.4	45.6	46.4
Орон сууцны байшин	4.4	17.4	23.3	26.0
Бие даасан тохилог сууц	3.9	1.7	2.8	2.5
Сууцны тусдаа байшин	15.6	29.8	18.3	15.2
Нийтийн байр	0.0	6.6	1.1	2.7
Зориулалтын бус сууц	0.6	0.0	0.0	0.2
Бусад	0.0	0.8	0.0	0.0
Сууцны эзэмшил				
Хувийн	97.8	57.0	90.0	73.9
Бусдын сууцанд түрээстэй	0.6	8.3	2.8	9.4
Бусдын сууцанд түрээсгүй	1.7	34.7	7.2	16.7
Өрхийн тоо	180	121	180	520

Хот суурин газар болон, хөдөө орон нутагт оршин сууж буй шилжигч, шилжигч бус өрхүүдийн газар, мал эзэмшиж, өмчлөж байгаа байдалд ялгаа их байна. Эзэмшлээр харахад, хот, хөдөөгийн шилжигчдийн дунд газар эзэмших байдал маш бага байна (Хүснэгт 4). Хэдий ийм ч хөдөөгийн шилжигчдийн хувьд газраа өмчилж авсан байдал болон мал маллах зорилгоор малтай байх явдал илүү өндөр хувьтай байна. Түүнчлэн, газар эзэмшдэг гэж хариулсан нийт өрхөөс цөөн хэдэн хувь нь газар тариалангийн зориулалтын газартай, түүнийх нь дундаж хэмжээ харьцангуй бага, ялангуяа шилжигч өрхөд бага байгаа нь газар тариалан биш, мал аж ахуй эрхлэх гэж газар эзэмшиж байгааг харуулж байна.[3]

Хүснэгт 4: Газар, малтай эсэх (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Газар эзэмшил	73.9	30.6	50.0	29.2
Хувьчилж авсан	79.0	91.9	90.0	81.6
Хувьчлаагүй	21.1	8.1	10.0	18.4
Тариалангийн газартай эсэх	6.1	1.7	2.8	2.1
Тариалангийн газрын дундаж (медиан) хэмжээ (га)	1.00	0.02	1.00	0.53
Малтай эсэх	17.8	82.6	23.3	12.7
Өрхийн тоо	180	121	180	520

Ихэнх өрхүүд эрчим хүчинд холбогдсон байгаа хэдий ч хөдөөгийн шилжигч бус өрхүүдийн эрчим хүчинд холбогдсон хувь нэлээд бага байгаа тул халаалт болон хоол ундаа болгоход малын аргал, хөрзөнг түлш болгон ашиглаж байна. Хүснэгт 5 өрхүүдийн эрчим хүч болон халаалтын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байдал мөн халаалт болон хоол унд хийхэд ашигладаг түлшний төрлийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан өрхийн дийлэнх олонх нь цахилгааны шугам сүлжээнд холбогдсон, өөрөөр хэлбэл, цахилгаан түгээх албан ёсны орон нутгийн байгууллагатай гэрээ хийсэн гэсэн үг. Тэгсэн хэдий ч хөдөө орон нутагт амьдарч байгаа шилжигч бус өрхүүдийн нэлээд хувь нь хүн ам оршин суугаа төвлөрсөн газраас алслагдсан, нүүдлийн хэв маягаар амьдарч байгаа учир цахилгаангүй байна. Бүх бүлгүүд ялгаагүй төвлөрсөн халаалт эсвэл нам даралтын зуух болон ердийн галлагааны аргаар халаалтыг хангаж байгаа бол хөдөө орон нутаг дахь шилжигч бус өрхүүд ердийн галлагаагаар өөрсдийн халаалтын хэрэгцээг илүүтэйгээр хангаж байна.

Шилжигч өрхүүд модыг халаалтанд, түүхий нүүрсийг хоол унд хийхэд гол төлөв ашиглаж байгаа ба энэ нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Шилжигч болон шилжигч бус өрхүүдийн дийлэнх олонх нь

3 Монгол Улсын Газар өмчлөх, эзэмших тухай хууль (2002)–аар байршлаас хамаарч гэр бүлийн хэрэгцээнд зориулж газар эзэмшүүлнэ гэж заажээ. Улаанбаатар болоод аймаг, нийслэлийг холбосон улсын чанартай төв зам дагуух газруудад иргэн бүр 0.07 га буюу 700 метр кв газар, аймгийн төвд 0.35 га буюу 3,500 метр кв газар, сумын төвд 0.5 га буюу 5,000 метр кв газар тус тус эзэмшүүлнэ гэжээ. Газрыг үнэ төлбөргүйгээр 2005–2013 оны хооронд эзэмшүүлэхээр заасан байна.

цахилгаан эрчим хүчинд холбогдсон ч эрчим хүчний өндөр үнэ тарифаас болж халаалт болон хоол хийхдээ нүүрс, аргал, мод илүү түлдэг байна. Жишээлбэл, нам даралтын зуух, ердийн галлагаатай өрхүүдийн дийлэнх нь халаалтын зориулалтаар түүхий нүүрс хэрэглэдэг бол хөдөөгийн шилжигч бус өрхүүд голдуу аргал хөрзөн хэрэглэдэг байна. Шилжигч бус өрхтэй харьцуулбал хот, хөдөөгийн шилжигч өрхүүд гол төлөв модыг түлээнд ашигладаг байна. Халаалтаас илүү хоол хийхэд харьцангуй олон өрх цахилгаан ашиглаж байгаа ч амьдарч байгаа газраас шалтгаалан мод, түүхий нүүрс, аргал түлж байгаа өрхүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байна. Тухайлбал, хөдөөгийн шилжигч бус өрхүүд хоол унд хийхдээ гол төлөв аргал ашиглаж байгаа бол хот, хөдөөгийн шилжигч өрхүүдийн түүхий нүүрсний ашиглалтын хувь хамаагүй өндөр байна. Хот суурин газрын шилжигч өрхүүдийн халаалтанд мод, хоол унд хийхдээ түүхий нүүрсний хэрэглээ харьцангуй өндөр байгаа явдал амьдарч байгаа орчныхоо агаарын бохирдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Хүснэгт 5: Цахилгаан, халаалт, хэрэглээний түлшний төрөл (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Цахилгаантай эсэх	66.7	96.7	100.0	96.2
Халаалтын эх үүсвэр				
Төвлөрсөн систем	4.4	24.0	25.0	29.8
Цахилгаан халаагуур	0.0	0.8	1.1	0.0
Нам даралтын зуух/Ердийн галлагаа	95.6	75.2	73.9	70.2
Халаалтанд ашиглаж буй түлш				
Цахилгаан	0.0	0.0	0.0	0.3
Мод	2.3	33.0	9.0	22.2
Түүхий нүүрс	25.0	60.4	75.9	75.1
Аргал	72.7	4.4	15.0	1.6
Бусад	0.0	2.2	0.0	0.8
Хоол хийхэд ашиглаж буй түлш				
Цахилгаан	13.3	38.8	46.7	46.2
Мод	7.2	17.4	11.7	11.4
Түүхий нүүрс	11.1	40.5	27.8	38.3
Аргал	68.3	3.3	13.3	1.2
Бусад	0.0	0.0	0.6	3.1
Өрхийн тоо	180	121	180	520

Тэмдэглэл: “Бусад” ангилалд хийн түлш, угаасан нүүрсний дайвар бүтээгдэхүүнийг халаалтын зориулалтаар, харин хоол хийхэд ашигладаг түлшний “Бусад” ангилалд хийн түлш, ихэвчлэн гадуур хооллодог (гэртээ бус) зэргийг хамруулсан болно.

3.2. Ус, ариун цэврийн байгууламж

Хот суурин газрын бараг бүх өрх сайжруулсан ундны усны эх үүсвэр (төвлөрсөн системийг оруулснаар)–тэй байхад сайжруулаагүй ундны усны эх үүсвэр хэрэглэдэг хөдөөгийн шилжигч бус өрхүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байна. Зураг 11 өрхийн ундны усны эх үүсвэрийг харуулж байна, тухайлбал, оршин суугаа газарт усны шугамтай байх (өөрөөр хэлбэл, хувийн сууц, хашаа дотор), төвлөрсөн ус хангах шугам сүлжээ, сайжруулсан усны бусад эх үүсвэр, жишээлбэл, нийтийн ус түгээх төв, хамгаалагдсан худаг, булаг шанд, цуглуулсан хур борооны ус мөн хамгаалагдаагүй худаг, булаг шанд, ердийн хөсөгт зөөврийн ус, гадаргын ус (гол горхи, нуур цөөрөм гэх мэт) эсвэл савласан ус. Хотын нөхцөлд шилжигч болон шилжигч бус өрхүүд нэгэн адил бараг бүгдээрээ төвлөрсөн шугамд холбогдсон эсвэл усны сайжруулсан бусад эх үүсвэрээс усаа авч байна. Тэгвэл хөдөөгийн шилжигч бус өрхүүдийн бараг 30% нь сайжруулаагүй эх үүсвэрээс ундны усаа авч байгаа бол шилжин суурьшигч өрхийн 12% нь сайжруулаагүй эх үүсвэрээс ус авч хэрэглэж байна. Энд нэг ялгаатай зүйл нь шилжин суурьшсан өрхүүд төвлөрсөн ус хангах сүлжээнд холбогдсон байдаг байна.

Зураг 11: Ундны усны эх үүсвэр



Ихэнх өрхүүдийн хувьд ундны усны эх үүсвэрийн байршлын ялгаа төдийлөн их биш харин хөдөөгийн шилжигч бус өрхүүд усаа хол газраас зөөвөрлөдөг. Зураг 12–т хотын шилжигч, шилжигч бус өрх ялгаагүй амьдарч буй газартаа усны эх үүсвэртэй байгааг харуулж байна. Гэхдээ хотын өрхийн гуравны хоёр нь амьдарч байгаагаас өөр газраас буюу дунджаар гэрээсээ хагас ба түүнээс илүү километр газраас усаа зөөж байна. Хөдөө орон нутагт ялгаагүй шилжигч ба шилжигч бус өрхүүдийн дийлэнх олонх буюу 88% нь нэлээд хол газраас ус татаж авдаг. Түүнчлэн, оршин суугаа газарт усны эх үүсвэргүй шилжигч бус өрхүүд шилжигч өрхтэй харьцуулбал бараг 2 дахин хол газраас усаа зөөвөрлөж байна (тус бүр 675 метр, 386 метр хол газраас).

Зураг 12: Усны эх үүсвэрийн байршил, дундаж зай



Тэмдэглэл: шар өнгийн тэмдэг дундаж зайг метрээр илэрхийлж байгаа бөгөөд ундны усны эх үүсвэр нь хашаанаас гадуур өөр газарт байдаг өрхүүдийг харуулж байна.

Хотын шилжигч ба шилжигч бус өрхүүдийн ундны усны эх үүсвэрийн байршлын зай бараг ижил байгаа ч шилжигч өрхүүд усаа зөөвөрлөхөд харьцангуй илүү цаг зарцуулдаг байна. Дээр тэмдэглэсэнчлэн, хот суурин газрын шилжин суурьшсан өрхүүд байнгын оршин суугаа нүүж шилжээгүй өрхтэй нэгэн адил зайтай газраас усаа зөөвөрлөдөг хэрнээ ус авах гэж 4 дахин (19%–ыг 5%–тай харьцуулах) илүү цаг зарцуулж байгаа нь нийтийн ус түгээх цэгт урт дараалалд удаан хүлээдэгтэй холбоотой байж болзошгүй. Гэвч эдгээр өрхүүд ус авахад зарцуулж байгаа цагийн зөрүү тийм их биш.

Хөдөөгийн шилжигч бус өрхүүдэд сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж маш доогуур байгаа бол хот суурин газарт шилжигч өрхүүд ариун цэврийн дундын байгууламжийг ашиглах явдал илүү байна. Судалгаанд хамрагдсан дийлэнх хүн амын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг Зураг 13–аас үзэж болно. Байдал ийм байгаа ч хөдөө орон нутгийн шилжигч бус өрхүүдэд ариун цэврийн ийм байгууламж байхгүй учраас ил задгай бие засч байна. Түүнчлэн, хот суурин газар шилжин ирсэн өрхийн 10 орчим хувь нь дундын буюу нийтийн ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа ба энэ үзүүлэлтээр шилжигч бус өрхтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Зураг 13: Ариун цэврийн байгууламж



Хот, хөдөөд хог хаягдлаа зайлуулах байдлын ялгаа их байгаа ба ялангуяа хөдөөгийн шилжигч бус байнгын оршин суугаа өрхүүд ахуйн хог хаягдлаа зайлуулдаг тусгайлан тогтсон газаргүй байна. Хотын өрхүүдийн ахуйн хог хаягдлыг тусгай үйлчилгээний байгууллагууд зайлуулахаас гадна хог хаядаг зориулалтын цэгтэй байгааг Зураг 14 харуулж байна. Хотын нөхцөлд хог хаягдлыг ийм хоёр аргаар зохицуулж байгаа ч хот суурин газарт шилжин суурьшсан өрхүүд зориулалтын хогийн цэгт хогоо хаядаг нь ерөнхийдөө тэдгээрийн эмзэг байдлыг илтгэж байна. Нөгөөтэйгүүр хог хаягдлаа тусгай үйлчилгээгээр зайлуулж байгаа хөдөөгийн өрхүүдийн эзлэх хувь нь маш бага байдаг төдийгүй хог хаягдлаа зайлуулах тогтсон зориулалтын цэггүй байдаг тул хогоо ил задгай хаяж байгаа нь хөрсний бохирдлын эрсдэлийг бий болгодог.

Зураг 14: Хог хаягдал зайлуулах байдал



3.3. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ

Хөдөөгийн шилжигч бус өрхүүд эрүүл мэндийн үйлчилгээнээс харьцангуй хол амьдарч байгаа нь хөдөөгөөс хот руу шилжин суурьшихад хүргэж байна. Харин хотын шилжигч, шилжигч бус өрхүүд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авах байдал харьцангуй өндөр байна. Хүснэгт 6–д хот, хөдөөд шилжигч болон шилжигч бус өрхүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн ялгаатай байдлыг харуулж байна. Хөдөөгийн алслагдсан нутагт амьдарч байгаа шилжигч бус өрхүүд өрхийн эрүүл мэндийн төв буюу сумын эмнэлгээс дунджаар 8.8 километр хол газарт амьдардаг ба тухайн орон нутагт нүүж ирсэн шилжин суурьшигчдийг бодвол шаардлагатай үед ч эрүүл мэндийн үйлчилгээ авах явдал харьцангуй бага байдаг. Тэгвэл хот суурин газарт шилжин суурьшигч өрхүүд эрүүл мэндийн төв, эмнэлгээс нэлээд зайтай хол оршин сууж байгаа ч шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авах явдал шилжигч бус өрхтэй харьцуулахад өндөр байна.

Хот, хөдөөд ялгаагүй шилжигч өрхүүдийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдах, эмчийн зөвлөгөө авах хувь хэмжээ өндөр байна. Судалгаанаас 6 сарын өмнө эрүүл мэндийн үйлчилгээг өрхүүд авсан байдлыг Хүснэгт 6 харуулж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа хамгийн түгээмэл учир шалтгаан нь эмчийн зөвлөгөө авах, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт орох бөгөөд ийм үйлчилгээг хот, хөдөө ялгаагүй шилжигч бус өрхийг бодвол шилжин суурьшсан өрхүүд илүү авдаг байна. Мөн шилжигч бус өрхүүд эмнэлгийн нарийн мэргэжлийн үйлчилгээ эсвэл архаг өвчний хяналт зэрэг эмчийн нарийн мэргэжлийн тусламж авах явдал илүү өндөр байна. Түүнчлэн, хотын шилжин суурьшигчдийн дунд төрөхийн өмнөх жирэмсний үеийн тусламж, вакцинжуулалт, 0–1 насны хүүхдийн эмнэлгийн идэвхтэй хяналтад хамрагдах нь харьцангуй өндөр байна.

Эрэлт хэрэгцээ харилцан адилгүй байгаа ч эрүүл мэндийн үйлчилгээг авч чадаагүй байгаа шалтгааныг олж тогтоох явдал илүү чухал байна. Тухайлбал, хөдөө орон нутагт шилжин суурьшигчид оршин суух бүртгэлгүй эсвэл мөнгөний боломжгүйгээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа гэж хариулж байгаа бол хот суурин газарт нүүж ирсэн шилжин суурьшигчид ийм үйлчилгээг авч чадахгүй байгаа нь эмнэлэг хол эсвэл эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу зэрэг шалтгааныг дурддаг болов уу. Дээрх байдал оршин суух бүртгэлээ албан ёсоор хийлгэхийн ач холбогдлыг харуулж байгаа төдийгүй бүртгэлгүй бол хүндрэл бэрхшээлтэй тулгарч болох талаар хэлж буй хэрэг юм. Нөгөөтэйгүүр, хот, хөдөөгийн шилжигч бус өрхүүд ялгаагүй ажил ихтэй завгүй байдгаас эрүүл мэндийн төвд очиж чаддаггүй гэж хэлэх нь түгээмэл байна.

Хүснэгт 6: Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Өрх, сумын эмнэлэг хүртэлх дундаж зай (км)	8.8	1.7	1.0	1.8
Сүүлийн 6 сарын хугацаанд шаардлагатай үед эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал	90.1	96.4	83.3	91.0
Хамрагдсан эрүүл мэндийн үйлчилгээний төрөл …(*)				
Эмнэлгийн яаралтай тусламж	2.2	7.5	7.0	5.3
Жирэмсний хяналт	12.1	11.3	11.3	16.4
Вакцинжуулалт	16.5	12.5	15.7	26.0
Архаг өвчний хяналт	12.1	8.8	14.8	10.2
0–1 насны хүүхдийн эмнэлгийн идэвхтэй хяналт	18.7	17.5	14.8	25.0
Урьдчилан сэргийлэх үзлэг	33.0	56.3	32.2	47.0
Эмчийн зөвлөгөө	42.9	52.5	41.7	55.9
Нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж	34.1	12.5	33.0	22.4
Бусад	1.1	0.0	0.9	0.7
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй шалтгаан…(*)				
Бүртгэлийн бичиг баримт дутуу	6.1	51.5	0.0	0.0
Эмнэлэг хэтэрхий хол	3.0	6.1	0.0	33.3
Эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу	3.0	24.2	10.0	66.7
Хэт их дараалалтай, ачаалал их	21.2	18.2	30.0	0.0
Мөнгө байхгүй	0.0	27.3	0.0	0.0
Завгүй, ажил ихтэй	63.6	9.1	70.0	0.0
Бусад	0.0	12.1	0.0	0.0
Өрхийн тоо	180	121	180	520

Тэмдэглэл: (*)судалгаанаас 6 сарын өмнө эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан өрхийг тооцоонд оруулав. Эрүүл мэндийн үйлчилгээг авч чадаагүй шалтгааныг тооцоход судалгаанаас 6 сарын өмнө ийм үйлчилгээнд хамрагдаж чадаагүй өрхийг авч үзсэн. Хоёулаа олон сонголттой хариулт бүхий асуулт байсан тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү байж болно.

Шигтгээ 1: Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх чанарын судалгааны мэдээллээс

Шилжин суурьшигчдийн тоо өсөн нэмэгдэж байгаагаас шалтгаалж эмнэлэг, сургуулийн ачаалал нэмэгдэж байна. Сумын хэмжээнд бүртгэлтэй 18,500 орчим хүн байна харин явуулын бүртгэлгүй иргэдийн тоо 5,000 байна. Суурь үйлчилгээний чанарыг сайн гэж хэлэхгүй, гэвч чанаргүй үйлчилгээ үзүүлээд байгаа зүйл ажиглагдахгүй байгаа. Багш, эмч нарын мэдлэг, чадвар хангалтгүйн улмаас үйлчилгээний чанар муу байгаа болохоос биш нэг эмч, багшид оногдож байгаа өвчтөн, сурагчдын тооноос болохгүй байгаа. Хэрвээ тухайн иргэн бүртгэлтэй бол төрийн бүх үйлчилгээг авах боломжтой. Боловсон хүчний мэдлэг, мэргэжил, харилцааны ур чадвар харин бүгд сайн байгаа. Сумын иргэдийн тоо нь зохих хэмжээнээс хэтэрсэн хэдий ч төрийн бүх шатны албан хаагчид, түүний дотор өрхийн эмч, хэсгийн ахлагч, иргэний бүртгэлийн ажилтнууд ажил үүргээ хангалттай биелүүлж төрийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэж байна.

–Дорноговь аймгийн Замын–Үүд сумын Засаг дарга Б.

Өрхийн эрүүл мэндийн гурван төв (ӨЭМТ) ажилладаг. Хөдөлмөрийн нөхцөл, боловсон хүчний асуудал бий, мөн үйлчилгээний чанар хангалтгүй. Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ нь хангалттай, сүүлийн хэдэн жилд олон шинэ тоног төхөөрөмж суурилуулсан, гэвч эмнэлгийн дарга ажлын байранд тогтдоггүй байнга солигддог, үүнээс гадна боловсон хүчин дутагдалтай байгаа.

–Сүхбаатар аймгийн Баруун–Урт сумын нийгмийн ажилтан С.

Хүмүүс оршин суух хоёр өөр хаягтай байдаг болохоор төрийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй байдаг. Эмнэлэгт үзүүлэхэд ч төвөгтэй. Би улирлын чанартай ажил эрхэлдэг, өвөл эмчлүүлмээр байдаг, толгой байнга өвддөг, хувийн эмнэлэгт үзүүлэхэд мөнгө төлбөр төлнө.

–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 26–р хорооны шилжин суурьшигч, 32 настай Т.

ӨЭМТ–ийн ачаалал их гэвч үйлчилгээний чанар нь сайн. Манайх хорин мянган хүн амтай том хороо, ачааллаа даваж чаддаг, бүртгэлгүй эхүүдийг эрж хайж олдог. Шинээр төрсөн эхчүүдийг эмч нар өөрсдөө эрж хайж олж эмнэлгийн үзлэгт оруулдаг. Машин тэрэг, тоног төхөөрөмж хангалтгүй, хүртээмж муутай. Би хорооны ӨЭМТ–д үзүүлдэг, дүүргийн эмнэлэгт очиж байгаагүй. Дүүргийн эмнэлэг оочиртой байдаг учир эмчид үзүүлэх нь тийм ч амар зүйл биш.

–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 22–р хорооны шилжин суурьшигч, 47 настай Н.

Хотын шилжигч өрхүүдийг шилжигч бус өрхтэй харьцуулахад хамгийн ойрын дунд сургуулиас нэлээд хол зайд суурьшсан байгаа нь тэд ихэвчлэн хотын захаар суурьшсаныг илтгэнэ. Хот, хөдөөд шилжигч болон шилжигч бус өрхийн боловсролын хүртээмжийн байдлыг Хүснэгт 7 харуулж байна. Хотын шилжигч бус өрхийг бодвол хотод шилжин ирсэн өрхүүд хамгийн ойрын дунд сургуулиас нэлээд хол байдаг байна, тухайлбал, шилжигч бус өрхүүд сургуулиас дунджаар 1.1 км хол гзарт байдаг бол шилжигч өрхүүд 6.8 км хол зайнд суурьшсан байна. Нөгөө талаар, хөдөө орон нутагт амьдардаг шилжигч бус өрхүүд сургууль, нийгмийн бусад үйлчилгээнээс дунджаар 14.9 километр хол газар амьдарч байгаа нь тэдний алслагдсан нөхцөл байдлыг илэрхийлж байна.

6–аас 15 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин ерөнхийдөө өндөр байна. Хүснэгт 7–оос хот, хөдөө мөн шилжилтийн статусаас үл хамааран цөөн тооны сургуулийн насны хүүхдүүд сургуульд өдөр бүр суралцахгүй байгааг харж болно. Хөдөөгийн шилжигч бус өрхийн цөөн хүүхэд гэрээс сургууль хол байдаг учраас сургуульд явахгүй байгаа гэсэн шалтгаан хэлж байна. Харин хотод шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд ядуурал, оршин суух бүртгэлгүйн улмаас сургуульд явахгүй байна.

Хүснэгт 7: Боловсролын хүртээмж (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Сургуульд хүрэх зай (км)	14.9	5.7	1.1	6.8
6–15 насны хүүхдийн сургуульд хамрагдалт	97.8	99.2	99.4	99.6
Сургуульд хамрагдаж чадаагүй шалтгаан…(*)				
Дэндүү хол	25.0	0.0	0.0	0.0
Ядуу, мөнгө байхгүй	0.0	0.0	0.0	50.0
Оршин суух бүртгэлгүй	0.0	0.0	0.0	50.0
Бусад	75.0	100.0	100.0	50.0
Өрхийн тоо	180	121	180	520

Тэмдэглэл: (*) олон сонголттой хариулт бүхий асуулт байсан тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү байж болно.

Шигтгээ 2: Боловсролын үйлчилгээний хүртээмжийн талаарх чанарын мэдээллээс

Хэдийгээр суурь үйлчилгээний хүртээмж хангалттай байгаа ч үйлчилгээний чанарын асуудлыг анхаарах шаардлагатай. Суманд ихэвчлэн бүрэн бус дунд сургууль байдаг учраас ахлах ангид суралцахын тулд айл өрх аймгийн төв рүү хүүхдээ дагаж яваад эргэж ирдэггүй тохиолдол элбэг байна. Хэдийгээр цэцэрлэгийн хүртээмж хангалттай ч малчид хүүхдүүдээ цэцэрлэгт хамруулах боломжгүй байдаг учир тэд бага насны хүүхдээ сумын бага сургуульд оруулахын тулд сум руу нүүдэг. Тийм учраас хөдөөний багийн бараг бүх өрх сумын төвд гэртэй байдаг болохоор малчин хоёр тусдаа өөр газарт амьдардаг нь гэр бүлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг гэж боддог.

–Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын орлогч Л.

Манай хорооны 65 дугаар сургууль ачаалал ихтэй: хүүхдүүд 3 ээлжээр хичээллэдэг. Хотод шилжиж ирсэн өрхийн нэлээд хэдэн хүүхдүүд, 8–9 хүүхэд байх, одоо болтол сургуульд ороогүй байна. Хүүхдээ сургууль олж оруулж өгөөч гэж гуйж явдаг эцэг эхчүүд бий. Ийм хүүхдүүдийг албан бус сургалтад хамруулах арга хэмжээ авдаг. Баянхошуунд байдаг 12 дугаар сургууль эндээс нэлээд зайтай шүү. 6–р хэсгийн 5, 3–р хэсгийн бүх хүүхдүүдийн гуравны хоёр, мөн 1–р хэсгийн нэг хүүхэд байх, эд бүгд албан бус сургалтад хамрагдаж байгаа. Албан бус сургалтанд 4–р ангиас дээш насны хүүхдүүдийг л авдаг.

–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 26–р хорооны зохион байгуулагч, 42 настай М.

3.4. Ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр төр засгаас авах арга хэмжээ

Төр засгаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнд дэд бүтэц, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах явдлыг тэргүүлэх зэргийн анхаарвал зохих асуудал гэж өрхүүд үзэж байна. Амьжиргаа/ахуйн нөхцөлийг сайжруулахад төр засгаас хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээний талаар өрхийн санал бодлыг Хүснэгт 8–аас үзэж болно. Хот хөдөөгийн түвшинд хоёр бүлгийн өрхүүд хоёулаа зохистой дэд бүтэц, хөдөлмөрийн нөхцөл (тухайлбал, урт хугацааны хөдөлмөрийн гэрээ, өндөр цалин хөлс)–ийг сайжруулахын чухлыг онцолсон байна. Хотын шилжигч, шилжигч бус өрхүүд орон байрны нөхцөлийг сайжруулахыг чухалчилж байгаа бол хот, хөдөөгийн шилжигч бус өрхүүд бизнес эрхлэх таатай орчинг бий болгоход анхаарах нь зүйтэй гэж үзсэн байна. Мөн түүнчлэн, шилжин суурьшигч өрхүүд, ялангуяа, хөдөө орон нутагт амьдарч байгаа шилжигч өрхүүд эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх асуудлыг онцолжээ.

Хүснэгт 8: Амьжиргаа/ахуйн нөхцөлийг сайжруулах талаарх санал бодол (%)

	Хөдөө		***Хот***	
	Шилжигч бус	**Шилжигч**	**Шилжигч бус**	**Шилжигч**
Дэд бүтцийг сайжруулах	32.8	42.1	47.5	37.8
Орон сууцжуулах	16.1	19.0	35.2	33.6
Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх	18.3	6.6	24.0	11.8
Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах	44.4	36.4	33.0	38.4
Өндөр чанартай эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай болох	13.9	26.4	13.4	11.8
Өндөр чанартай боловсролын үйлчилгээ	7.8	5.0	4.5	7.5
Засаг захиргааны илүү боловсронгуй дүрэм журам	13.9	5.0	10.6	6.9
Сайн засаглал	8.9	6.6	8.9	4.6
Амьдралын таатай орчин	23.3	28.1	16.2	32.8
Мэдээлэл авах таатай боломж	2.8	5.8	2.2	1.5
Олон нийтийн ялгаварлан гадуурхалтаас хамгаалах	7.8	0.0	5.0	1.7
Хариулахыг хүсэхгүй байна	0.0	0.0	0.0	0.2
Мэдэхгүй	1.7	0.0	0.0	0.0
Бусад	3.3	9.9	3.4	8.3
Өрхийн тоо	180	121	179	518

Тэмдэглэл: олон сонголттой хариулт бүхий асуулт байсан тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү байж болно.

4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХӨДӨЛГӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

4.1. Шилжих хөдөлгөөний урсгал

Улаанбаатарт шилжин суурьшиж байгаа шилжигчид гол төлөв хөдөө орон нутгаас ирж байгаа бол "шилжин суурьшсан нутаг" гэж сонгосон хоёр аймагт шилжих хөдөлгөөний урсгал нь өөр байна. Өрхийн судалгаанд нийт 641 шилжигч өрхийг шилжин суурьшсан гурван нутгаас хамруулсан: Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорноговь аймаг. Зураг 15–д дотоод шилжих хөдөлгөөний чиглэл, урсгалыг хот, хөдөөгөөр ангилан харуулж байна. Бидний таамаглаж байснаар, шилжин суурьшсан гурван нутагт хөдөөгийн шилжигчид дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын тухайд хөдөөгөөс хот руу шилжсэн шилжигчид илүү давамгайлж байна. Хотоос хот руу шилжсэн шилжигчид бүх газруудад мэдэгдэхүйц байгаа ч Сэлэнгэ, Дорноговь аймгийн хувьд хотоос хөдөө рүү шилжигчид мөн нэлээдгүй байна. Тэгэхээр шилжих хөдөлгөөний энэхүү холимог байдал нь Монгол улсын дотоод шилжилтийн мөн чанарыг илтгэж байгаа бөгөөд нийт шилжилтэд дан ганц хөдөөгөөс хот руу шилжигчид давамгайлаагүй гэдгийг харуулж байна.

Зураг 15: Шилжих хөдөлгөөний урсгал



Дорноговь, Сэлэнгэ аймагт дотроо шилжих хөдөлгөөн илүү давамгайлж байгаа бол Улаанбаатарт байдал өөр байна. Дотоод шилжих хөдөлгөөн хол зайд явагддаг гэж үндсэндээ ойлгодог боловч шилжин суурьшигч хүн амын томоохон хэсэг нь уугуул аймаг дотроо нүүдэл суудал хийж байна. Дорноговь аймгийн хувьд, шилжигч хүн амын бараг тал хувь нь аймаг дотроо, Сэлэнгийн шилжигчдийн дөрөвний нэг орчим нь мөн аймаг дотроо тус тус шилжсэн байна. Харин нийслэл Улаанбаатарын хувьд дотоод шилжилт бага байна.

Шигтгээ 3: Шилжих хөдөлгөөний урсгалын талаарх чанарын судалгааны мэдээллээс

Сүүлийн 10–аад жилд шилжин суурьшигчдийн тоо байнга өсөн нэмэгдсэн. Ойрын 3 жилд энэ тоо буурахгүй харин улам бүр нэмэгдэнэ. Өөр газар руу шилжин явж байгаа иргэдийн тоо шилжин ирж байгаа иргэдийн тооноос хамаагүй бага байна. Шилжих хөдөлгөөнд хориг тавьсан хэдий ч шилжин суурьшигчид энд ирээд ямар ч бүртгэлгүй амьдарсаар байна.

–Дорноговь аймгийн Замын–Үүд сумын Засаг дарга Б.

Ихэнх тохиолдолд, шилжигч өрхүүд одоогийн суурьшилдаа цөөхөн жил амьдарч байгаа нь эдгээр газрууд руу чиглэсэн шилжилтийн сүүлийн үеийн урсгалыг харуулж байна. Зураг 16–д судалгаа авахаас өмнө одоогийн амьдарч буй байршилдаа хэдий хэр удаан амьдарч байгааг харуулсан мэдээллийг үзүүлэв. Мэдээллийг хот, хөдөөгийн байршлаар, шилжин суурьшсан нутгаар харуулав. Шилжигч өрхүүдийн дийлэнх олонх нь сүүлийн 3 жилийн хугацаанд одоогийн байршилдаа шилжин ирэгчид байгаа бөгөөд сүүлийн нэг жилд шилжин ирэгчид тэдний дийлэнх байна. Улаанбаатар хотын хувьд 5 ба түүнээс дээш жилийн хугацаагаар амьдарч байгаа шилжигчид цөөнгүй байгаа нь нийслэл рүү чиглэсэн уламжлалт шилжилтийн урсгал байгааг мөн харуулж буй хэрэг юм.

Зураг 16: Одоогийн байршилд шилжиж ирснээс хойш амьдарч буй хугацаа



4.2. Шилжилтийн шалтгаан, шилжилтийн шийдвэр гаргах үйл явц

Эдийн засаг, гэр бүлийн шалтгаан болон амьжиргаа/ахуйн нөхцөлөө сайжруулах гэсэн хүсэл тэмүүлэл нь шилжигч өрхүүдийг уугуул нутгаа орхиход хүргэсэн хамгийн гол хүчин зүйлс болж байна. Зураг 17 шилжин суурьшсан аймаг бүрээр, хот, хөдөөгийн ялгаатай байдлаар шилжигчдийн уугуул нутгаа орхих болсон шалтгааныг харуулж байна. Сонирхолтой нь, Дорноговь аймагт хөдөө орон нутаг руу шилжигч өрхүүд ихэвчлэн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эдийн засгийн боломж муу байгаа шалтгааны улмаас шилжин суурьшсан бол аймгийн хот сууринд шилжин ирэгч өрхүүд хөдөө амьжиргаа/ ахуй нөхцөл хангалтгүй гэсэн шалтгаанаар шилжин суурьшсан байна. Эдийн засгийн шалтгаан бүх бүлгийн хувьд түгээмэл байна, ялангуяа, Улаанбаатарт шилжигчдийн дийлэнх хувь нь ийм шалтгаанаар шилжин суурьшсан байна. Энэ нь уугуул нутагт ажлын байрны хомсдол өндөр, харин хот суурин газарт хөдөлмөр эрхлэх илүү боломжтой гэсэн шинж тэмдэгийг илэрхийлж байна.

Зураг 17: Уугуул нутгаа орхин шилжсэн шалтгаан



Шилжилтийн шалтгаан шилжин суурьшсан нутаг хооронд ялгаатай байна. Зураг 18–аас харахад, Дорноговь аймгийн хөдөөд шилжин ирэгчдийн дунд эдийн засгийн шалтгаан давамгайлж байгаа бол уг аймгийн хотод шилжин ирэгчдийн дунд амьжиргаа/ахуйн нөхцөлөө сайжруулах зорилго өндөр байна. Бусад тохиолдлуудтай харьцуулахад, гэр бүлийн шалтгааны улмаас шилжилт оролцох байдал мөн чухал байна. Мөн түүнчлэн, Улаанбаатар хотод шилжин ирэгч өрхүүдийн хувьд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнээс шалтгаалсан шилжигчид өндөр, харин Дорноговьд энэ хувь харьцангуй бага байна. Энэ нь хот суурин газар эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний байгууллагууд

төвлөрөхийн зэрэгцээ хүртээмж, чанарын хувьд өндөр байдгийг харуулж бүй хэрэг бөгөөд нийгмийн үйлчилгээний хүртээмжийг илэрхийлсэн нотолгоо болж байна.

Зураг 18: Шилжин суурьшсан нутгаа сонгосон шалтгаан



Өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс уугуул нутгаас шилжих, шилжин суурьших нутгаа сонгоход ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Ахимаг настай өрхийн тэргүүлэгчид, ялангуяа, 60 ба түүнээс дээш настны хувьд гэр бүлийн шалтгааны улмаас шилжих шийдвэр гаргаж байгаа нь шилжин суурьшсан нутагт байгаа өрхийн бусад гишүүдтэйгээ ойртох зорилготой байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тухайд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад, гэр бүлийн гишүүддээ ойртох шалтгаан бараг 13 хувиар илүү байна. Эсрэгээрээ, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд ажил эрхлэлттэй холбоо бүхий эдийн засгийн шалтгааны улмаас шилжилтэд оролцох байдал өндөр байна.

Эдийн засгийн шалтгааны улмаас шилжилтэд оролцсон өрхийн тэргүүлэгчдийн дийлэнх хувь нь шилжин суурьшсан нутагтаа очоод цалин хөлстэй ажил, эсвэл өрхийн бизнес эрхлэж байна. Бид шилжих хөдөлгөөний өмнө болон дараах хөдөлмөрийн зах зээлийн идэвхийг харьцуулах боломжгүй боловч эдийн засгийн шалтгааны улмаас шилжилтэд оролцсон хүн амын шилжилтийн зорилгоо биелүүлж чадсан эсэхийг гаргах боломжтой байв. Эдийн засгийн шалтгааны улмаас шилжих хөдөлгөөнд оролцсон өрхийн тэргүүлэгчдийн дийлэнх хувь нь цалин хөлстэй ажилтай болсон эсвэл өрхийн аж ахуй, хувийн бизнес эрхэлж байгаа нь мал аж ахуй, газар тариалан эрхэлж бүй хувь хэмжээнээс харьцангуй өндөр байна.

Шигтгээ 4: Шилжилтийн шалтгааны талаарх чанарын судалгааны мэдээллээс

Малгүй, ажилгүй, амьжиргаагаа сайжруулах боломж эрэлхийсэн хүмүүс л Улаанбаатар хот руу шилжиж ирдэг. Эдний зарим нь зуднаар малаа алдсан, үр хүүхэд нь хотод их дээд сурьгуульд оюутан болсон, эсвэл ач зээгээ харах гэж гэрээр нүүж ирсэн гэсэн янз бүрийн шалтгаантай. Залуу хүмүүс Улаанбаатарт ажил хайж л ирж байна, гэвч мэдээж их хотын хөгжил, соёлд татагддаг байх.

–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 22–р хорооны зохион байгуулагч Д.

Айл өрх, ганц бие хүмүүс шилжин ирж байгаагийн хамгийн гол шалтгаан нь ажил хайх, үр хүүхдийнхээ ирээдүйг бодож чанартай сургууль бараадах юм. Уур амьсгалын өөрчлөлт шилжих хөдөлгөөнд нөлөөлөх нь маш бага. Гэхдээ ойрын жилүүдэд хур бороо бага, өвсний гарц муу байгаа нь цөөн толгой малтай малчдын хувьд суурин газар руу шилжиж амьжиргаагаа дээшлүүлэх шалтгаан болж байна.

–Дорноговь аймгийн Сайншанд сумын Нийгмийн бодлогын хөгжлийн хэлтсийн дарга О.

Амьдралаа дээшлүүлэх, нэг дороо амьдрах зорилгоор ирсэн. Тэгэхгүй бол гэр бүл хоёр газарт байх их хэцүү байна. Нөхөр маань хотынх, хувиараа ажил хийдэг. Би одоохондоо ажилгүй байгаа, ажил хайж л байна. Хүүхдээ цэцэрлэгт зөөж л өдөр өнгөрч байна. Нөхөр сардаа 500 мянган төгрөг олдог. Амьжиргаанд хүрэхтэй үгүйтэй байна. Ямар ч хамаагүй ажил хиймээр байна.

–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 26–р хорооны шилжин суурьшигч, 24 настай Л.

Баянгол сумд 2017 оны 9 сард ирсэн. Малчин авна гэсэн зарын дагуу нүүж ирсэн. Фермд малчин хийж байна. Сарын цалин 600 мянган төгрөг. Фермийн эзэд их сайхан хүмүүс байгаа. Том хашааг тусгаарлаад нэг жижиг хашаанд гэрээ барьсан. Одоо эндээс нүүх бодолгүй байгаа. Бүртгүүлээд эндхийн айл болно. Хүмүүсийн ааш занг таних гээд ирэнгүүтээ бүртгэл хийлгээгүй юм. Одоо харин ажил, фермийн эзэд их дажгүй байгаа болохоор суурьшихаар шийдсэн. Эндхийн ажил амар, үнээ саагаад өвөлдөө тэжээгээд, дулаарахаар бэлчээрт гаргадаг. Хашаа хороог цэвэрлэдэг.

–Сэлэнгэ аймгийн Баянгол сумын шилжин суурьшигч, 32 настай О.

Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнд байгалийн гамшиг нөлөөлж байна. Зун гантай байдаг, өвөл нь зуд болдог. Хүмүүс малаа алдаад, хөдөө олигтой ажил олддогүй учир хүмүүс хот газар, төвлөрлийг бараадан нүүж байна. Хөдөө орон нутагт зөрчил их гардаг. Олон малтай, хөрөнгөтэй, хамаатан садан олонтой айлууд бусдыгаа

хавчиж гадуурхдаг.
–Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 11–р хорооны шилжин суурьшигч, 37 настай М.

Зуданд малгүй болоод хүүхдүүдээ бараадаж хот руу орж ирсэн. Хөгшин бид хоёр тэтгэврт гарсан, сардаа тус бүр 250 мянган төгрөгийн тэтгэвэртэй. Хоол хүнсэнд хангалттай хүрдэг. Эндээ суурьшина. Гэвч шилжилт хийхгүй байгаа учир түр оршин суугчаар байж байна.
–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 26–р хорооны шилжин суурьшигч, 69 настай Л

Шилжигч өрхүүдийн дунд нүүхэд хүргэсэн гарцаагүй шалтгааны улмаас шилжилтэд оролцох байдал маш бага байна. Судалгаанд хамрагдсан өрхийн зөвхөн 4–хөн хувь байгаль цаг уурын гамшигт үзэгдлээс шалтгаалан шилжилтэд оролцох гарцаагүй тохиолдол үүссэн тухайгаа бүртгүүлсэн байна. Энэхүү шалтгаанд зуд орж байгаа бөгөөд зуднаар малаа алдсан учраас нүүхээс өөр аргагүй болсон аж. Эдгээр өрхүүдийн дийлэнх нь Улаанбаатар руу шилжсэн нь гайхаад байх зүйл биш юм.

Шилжих хөдөлгөөний шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэж байна. Зураг 19–д шилжин суурьшсан нутаг дахь шилжигч өрхүүдийг өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй эсвэл эрэгтэй эсэхээс хамааруулж, шилжилтийн шийдвэрийг гаргагчдыг ангилан харууллаа. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд шилжих шийдвэрийг өрхийн бусад гишүүд (өөрөөр хэлбэл хүүхдүүд, эцэг эх, ах, эгч, дүү)–тэй харьцуулахад эмэгтэйчүүд илүү гаргаж байна. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тухайд эхнэр нь шилжих шийдвэр гаргалтад илүү оролцоотой байгаа нь эмэгтэйчүүдийн оролцоо чухал байгааг мөн харуулж байна.

Зураг 19: Шилжилтийн шийдвэр гаргагч



Өрхийн бусад гишүүдийн хувьд хэрвээ шилжин суурьших нутаг хот суурин газар байхын бол шилжих шийдвэр гаргалтад оролцож байна. Шилжилтийн урсгал (жишээ нь: хөдөө–хот)–аар шилжилтийн шийдвэр гаргагчдыг харвал, өрхийн тэргүүлэгч болоод тэдний хосууд хооронд мэдэгдэхүйц хамаарлын хандлага ажиглагдахгүй байна. Өрхийн бусад гишүүд тухайлбал, хүү эсвэл охин, эцэг эх, ах, эгч, дүү нар Улаанбаатар зэрэг хот суурин газар руу шилжих тохиолдолд шилжилтийн шийдвэр гаргалтад оролцох байдал илүү байна. Энэ нь өмнө судлагдаж байсан шиг хот суурин руу шилжих шилжилтэд өрхийн шилжилт давамгайлж байгааг харуулж байж болох юм.

4.3. Шилжилтийн бэлтгэл, шилжих хөдөлгөөнтэй холбоотой зардал

Шилжихээсээ өмнө шилжин суурьших нутгийнхаа талаар мэдээлэл авсан байдал шилжигч өрхүүдийн хувь тун бага байна. Хүснэгт 9–д хөдөөгөөс шилжигчдийн зөвхөн тал орчим хувь нь шилжихээсээ өмнө тухайн газрынхаа талаар мэдээлэлтэй байсныг харуулж байна. Энэ үзүүлэлт бусад урсгалынхны хувьд харьцангуй өндөр байгаа ба хот руу шилжигчдийн дунд энэ хувь хамгийн өндөр байна. Мөн уугуул болон шилжин суурьших нутгаас хамаарч мэдээллийн төрөл ялгаатай байна. Жишээлбэл, хөдөөгөөс хот, эсвэл хотоос хот руу шилжигч өрх хөдөлмөр эрхлэлт, боловсролын боломж, байр сууцны нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээний тухай мэдээлэл олж авах байдал илүү байна. Харин хотоос хөдөө рүү шилжигчдийн тухайд амьжиргаа/ахуйн нөхцлийн талаар урьдчилан мэдэхийг илүү сонирхож байна.

Шилжин суурьшсан нутагт байгаа гэр бүлийн бусад гишүүд болоод найз нөхөд нь хот руу шилжигчдийн хувьд мэдээллийн хамгийн гол эх үүсвэр болж байна. Хүснэгт 9–д өрхийн бусад гишүүд, ялангуяа хамаатан садан хөдөөгөөс хот, хотоос хот руу шилжигч өрхүүдийн хувьд хэрхэн хамгийн гол мэдээллийг өгөгч болсныг харж болно. Сонирхолтой нь, хотоос хөдөө рүү шилжигчдийн хувьд өмнө тухайн газар нутагт амьдарч байсан гэж хариулт өгсөн нь тодорхой хугацааны дараа буцах шилжилтэд оролцож байгааг харуулж буй хэрэг юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах байдал нэлээд хязгаарлагдмал, интернет, фэйсбүүк зэрэг нь мэдээллийн харьцангуй чухал эх сурвалж болж байна.

Хүснэгт 9: Шилжихээс өмнө шилжин суурьших гэж байгаа газар нутгийн талаар мэдээлэл авсан байдал (%)

	Хөдөө–хот	Хөдөө–хөдөө	Хот–хөдөө	Хот–хот
Шилжин суурьшсан нутгийн тухай мэдээлэл авсан	68.0	51.4	64.3	72.8
Мэдээллийн төрөл				
Хөдөлмөр эрхлэлтийн боломж	57.2	42.1	38.9	55.0
Боловсрол, мэргэжлээ дээшлүүлэх боломж	27.5	0.0	0.0	22.1
Орон байрны нөхцөл	17.5	5.3	9.3	25.2
Эрүүл мэндийн үйлчилгээ	14.8	0.0	0.0	14.5
Зах зээл, дэлгүүр	14.0	5.3	9.3	20.6
Амьдрах орчин	40.2	26.3	50.0	45.0
Бусад	5.7	47.4	25.9	5.3
Мэдээллийн эх сурвалж				
Өмнө нь амьдарч байсан	7.8	21.1	35.2	11.3
Тэнд очиж байсан	35.5	31.6	29.6	30.8
Хүүхдүүд	14.3	5.3	5.6	8.3
Эцэг эх, ах эгч, дүү	19.9	21.1	14.8	21.1
Төрөл садан	45.5	26.3	27.8	42.9
Найз нөхөд	21.6	5.3	16.7	15.8
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	10.0	0.0	0.0	15.8
Зурагт	1.3	0.0	0.0	1.5
Сонин	0.0	0.0	3.7	1.5
Интернет	3.0	0.0	0.0	6.0
Фэйсбүүк	3.5	5.3	1.9	6.8
Твиттер	0.0	0.0	0.0	0.0
Орон нутгийн засаг захиргаа	0.4	0.0	0.0	3.0
Мэдэхгүй	0.4	0.0	0.0	0.0
Бусад	1.7	5.3	7.4	5.3
Өрхийн тоо	231	19	54	133

Өрхүүдийн шилжилтийн бэлтгэл шилжих хөдөлгөөний урсгалын хувьд онцын ялгаагүй байна. Зураг 20 шилжихийн тулд бэлтгэл хангасан байдлыг харуулж байна. Хөдөө рүү шилжих гэж байгаа өрхүүд шилжилтийн бүртгэлээ хийлгэж бэлтгэлээ хангаж байхад хот суурин газар руу шилжигчид ийм бэлтгэлийг бараг хийхгүй байна. Олон өрхүүд шилжихээсээ өмнө мал, гэр, орон байр, эдэлбэр газраа худалдсан байна. Мөн хот суурин газар руу шилжигч өрхүүд хотод орон байр, тухайлбал, орон сууцны байшин, гэр худалдан авах зэргээр шилжин суурьших бэлтгэлээ хангасан байдаг.

Зураг 20: Шилжилтийн бэлтгэл



Тэмдэглэл: асуулт олон сонголттой хариулттай тул хариултын хувийн жингийн нийлбэр 100% хүрэхгүй байж болно.

Шилжилтийн бусад урсгалтай харьцуулахад хөдөөгөөс хот руу шилжих зардал харьцангуй өндөр байна. Шилжих хөдөлгөөний урсгал аль тийшээ байгаагаас шалтгаалан шилжин суурьших нийт зардал (монгол төгрөгөөр) их ялгаатай байгааг Зураг 21 баталж байна. Урьдчилан таамаглаж байснаар, хөдөөнөөс хот руу шилжих шилжилт хамгийн өндөр зардалтай байхад, хот суурин газраас өөр хот суурин газар руу шилжих шилжилт хоёрдугаар байранд орж байна. Шилжих хөдөлгөөн хийхэд зардал зайлшгүй гардаг ч хөдөө орон нутаг руу нүүдэл суудал хийх зардал нэлээд хямд байна.

Зураг 21: Шилжих хөдөлгөөнтэй холбоотой зардал



5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ, СОРИЛТУУД

5.1. Уугуул нутагт тохиолдож буй сорилтууд

Судалгаанд хамрагдсан бүх газарт шилжигч болон шилжигч бус өрхүүд ялгаагүй уугуул газар нутагт эдийн засгийн асуудалтай хамгийн их тулгарч байна. Байнгын оршин суугч эсвэл шилжин суурьшсан өрх гэдгээс үл хамааран эдийн засгийн асуудал бүх өрхүүдийн өмнө тулгарч байгаа хамгийн гол асуудал болохыг Зураг 22–оос харж болно. Тодруулбал, шилжигч өрхүүд уугуул нутагтаа байхад ажил олдохгүй явдал хамгийн том асуудал байсан гэж үзэж байгаа бол шилжигч бус өрхийн хувьд мөн ялгаагүй энэ нь хамгийн том асуудал байгаа аж. Хот суурин газар, ялангуяа, Улаанбаатар хотод шилжин суурьшсан өрхүүд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагаа хамгийн том асуудал гэж үзэж байна. Шилжигч, ялангуяа хөдөөгийн шилжигч өрхүүд амьдралын нөхцөл, түүний дотор бэлчээрийн газаргүй байгаа нь хамгийн том асуудал гэж үзэж байгаа бол хот суурин газрын шилжигч бус өрхүүдийн хувьд орон байрны асуудал хамгийн хүндрэлтэй байдаг байна. Эдгээр дөрвөн дэд бүлгийн хувьд аюулгүй байдлыг том асуудал гэж тооцдоггүй байна. Шилжин суурьшигч өрхүүдийн дунд эдийн засгийн асуудал зонхилж байгаа нь уугуул нутгаас өрхүүд шилжих хөдөлгөөнд оролцохдоо эдийн засгийн асуудал гол түлхэц болж байна гэсэн өмнөх бүлэгт хийсэн дүгнэлттэй нийцэж байна.

Зураг 22: Уугуул нутагт өрхийн түвшинд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл



Уугуул нутагт орон нутгийн түвшинд ихэвчлэн хүнд суртал эсвэл байгаль орчны холбогдолтой хүндрэл, сорилтууд тулгарч байна. Зураг 23–т орон нутгийн түвшинд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шилжигчдийн хувьд өмнө амьдарч байсан уугуул нутгийн тухайд, шилжигч бус өрхийн хувьд одоогийн

амьдарч буй уугуул нутгийн түвшинд тодруулсныг харууллаа. Асуудал нэлээд холимог харагдаж байгаа ч засаг захиргааны шийдвэрүүд хүндрэлтэй (жишээ нь: дэндүү их цаас бичиг шаардах, урт хугацаанд хүлээх гэх мэт) байдгийг бүх бүлгийнхэн тэмдэглэн хэлсэн байна. Ялангуяа, хөдөөгийн шилжигч, хотын шилжигч бус өрхүүд үүнийг нэрлэх байдал өндөр байна. Орон нутгийн байгаль орчны бохирдол ихээхэн тулгамдсан асуудал мөн гэж бүх бүлгийнхэн, тэр дундаа хөдөөгийн шилжигч бус өрхүүд цохон тэмдэглэсэн байна. Хотын шилжигч өрхүүд мэдээллийн дутмаг байдал яах аргагүй нэг тулгамдсан асуудал гэдгийг дурьдсан бол шилжигч бус өрхүүд ялгаварлан гадуурхах байдал мөн тэдэнд сорилт бий болгож байгааг дурьдсан байна. “Бусад” гэсэн ангилал нэлээдгүй хувийг эзэлж байна. Үүнд улс төрийн тогтворгүй байдал, нам, улс төрийн хүчнээрээ хуваагдан талцах явдал, чөлөөт цаг өнгөрүүлэх газар дутмаг, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж муу, дэд бүтэц муу зэргийг оруулсан.

Зураг 23: Уугуул нутагт орон нутгийн түвшинд тохиолдож буй хүндрэл, бэрхшээл



Тэмдэглэл: шилжигч өрхөд тулгарсан хамгийн гол бэрхшээлд тэдний уугуул нутагт байх үеийн асуудлыг авч үзсэн бол шилжигч бус өрхийн хувьд тэдний одоогийн амьдарч буй уугуул нутагт тохиолдож байгаа бэрхшээлийг тус тус авч үзсэн. Асуулт олон сонголттой хариулттай тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү гарч болно.

Шигтгээ 5: Уугуул нутагт орон нутгийн түвшинд тохиолддог хүндрэл, бэрхшээлийн талаарх чанарын мэдээллээс

Шилжих хөдөлгөөн нь орон нутгийн засаг захиргаанаас явуулж байгаа бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй нарийн холбоотой гэж би боддог. Үүнийг манай сумын жишээ тод харуулж байна. Урьд нь манай аймаг бусад аймгуудаас хөгжлөөр хоцорч байсан. Сүүлийн

10 жилд аймаг хөгжүүлэх маш сайн бодлого хэрэгжүүлж, нутгийн иргэдийн оролцоо сайжирсны ачаар аймаг маань эрчимтэй хөгжиж, аймаг руу хүмүүс шилжин нүүж ирэх болсон. Хэдийгээр Улаанбаатар хотод ажлын байр байвч тийшээ шилжин нүүсэн хүмүүст хөгжин дэвжих боломжоор муу, шинэ орчинд дасан зохицох, байр сууриа олох гэсээр байтал цаг, зардал их гардаг учир хуримтлал үүсгэж чадахгүй болохоор нутагтаа буцаж ирж байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс нөхцөл байдлыг арай бодитоор харьцуулж сурч байна. Аймагтаа буцаж ирж байгаа хүмүүс нэлээд ядарсан байна шүү. Нэг зүйлийг хэлэхэд харамсалтай нь сүүлийн 2 жил хэт улс төржсөнөөс болж хөгжлийн эрч саарч байна. Шинэ Засаг даргын томилгооны хэрүүлээс болж хөгжлийн төлөвлөгөөг одоо болтол баталж чадаагүй байна. Ойрын 3 жилд шилжин ирэгчдийн тоо нэмэгдэх болов уу гэж найдаж байна. Гагцхүү аймгийн зөв удирдлагаас их зүйл шалтгаална даа.

–Сүхбаатар аймгийн Баруун–Урт сумын Нийгмийн асуудал хариуцсан засаг даргын орлогч

5.2. Шилжин суурьшсан нутагт тохиолдож буй хүндрэл, бэрхшээлүүд

Шилжин суурьшсан нутагт ирэх үед шилжигч өрхүүдийн дийлэнх хувьд ямар нэг хүндрэл бэрхшээл тохиолдоогүй байна. Гэвч суурьшсаны дараагаар байр сууц, газар эзэмших, ажлын байр байхгүй зэрэг асуудлууд үүссэн байна. Хүснэгт 10–д шилжигч өрхөд шилжин суурьшсан нутагт ирснээс хойш тохиолдсон хүндрэл бэрхшээлийг шилжилтийн урсгалаар харуулав. Шилжигч өрхийн дийлэнх олон нь ямар нэг хүндрэл бэрхшээлтэй учраагүй боловч хөдөөгөөс хот руу шилжин ирсэн өрхийн хувьд шилжилтийн бусад урсгалынхантай харьцуулахад хүндрэл тохиолдсон байна. Хөдөөгөөс хот руу шилжин ирэх үедээ байр сууцтай холбоотой хүндрэлтэй байдалтай тохиолдож байжээ. Хот суурин руу шилжигч өрхийн хувьд газрын зөвшөөрөл олдохгүй байх явдал мөн анхаарал татаж байна. Хотоос хөдөө рүү шилжсэн өрхөөс бусад өрхүүдийн хувьд ажил олдохгүй байгааг хамгийн тулгамдсан асуудал гэсэн байна.

Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн хөдөө нутаг руу шилжсэн өрхүүдийн хувьд шилжин ирэх үедээ олон хүндрэл бэрхшээлтэй учирсан байна. Хүндрэл, бэрхшээлийг шилжилтийн урсгалаар харвал, бусад урсгалынхантай харьцуулахад Улаанбаатар хотод болон Дорноговь аймгийн хөдөөд шилжин ирэгчдийн хувьд хүндрэл бэрхшээл нэлээдгүй тохиолдсон байна. Шилжигч өрхүүдийн хувьд тохиромжтой байр сууц олох нь ихээхэн түвэгтэй байсан төдийгүй газар олох, ажил хайх нь мөн л авъяас шаардсан зүйлс байсан тухай өгүүлжээ. Мөн хүндрэл бэрхшээл тулгарч байсан өрхийн зарим нь нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудал үүсч байсныг тэмдэглэсэн байна. Нийгмийн үйлчилгээний хүртээмж, тэр дундаа, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээтэй холбоотой тулгамдсан

асуудлын талаар төдийлөн байхгүй байгаа ч Дорноговь аймгийн хөдөөд шилжин ирэгчид эрүүл мэндийн үйлчилгээ авахтай холбоотой зарим нэг хүндрэл гарсан талаар онцолжээ.

Эмэгтэй тэргүүлэгчтэй шилжигч өрхийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад шилжин суурьшсан нутагтаа илүү хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Энэ хоёр бүлгийн хоорондын ялгаа төдий ноцтой биш болов ч эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөөс 5 хувиар илүү хүндрэл бэрхшээлтэй тулгарсан байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд тулгарсан бэрхшээлийн төрлийг тодруулбал, байр сууц, газрын зөвшөөрөл, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой хүндрэлүүд байна.

Хүснэгт 10: Шилжин суурьшсан нутагт тохиолдож буй хүндрэл бэрхшээл (%)

	Хөдөө–Хот	Хөдөө–хөдөө	Хот–хөдөө	Хот–хот
Ямар нэг бэрхшээл тохиолдсон	39.8	35.1	25.0	30.4
Бэрхшээлийн төрөл				
Орон байргүй байх	29.2	18.9	17.9	21.5
Газрын зөвшөөрөл олдохгүй	21.2	5.4	8.3	13.3
Ус, цахилгаангүй	5.0	5.4	0.0	3.3
Ажил олдохгүй	17.1	21.6	4.8	13.8
Хот газар дасахгүй	2.4	0.0	0.0	2.2
Сургууль, цэцэрлэг олдохгүй	3.8	2.7	1.2	3.3
Нийгмийн халамж, үйлчилгээ хүртэхгүй	6.8	8.1	3.6	2.8
Эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй	2.4	2.7	4.8	2.8
Бусдад ялгаварлан гадуурхагдах	0.6	0.0	1.2	0.0
Ариун цэврийн байгууламж байхгүй	0.0	2.7	0.0	0.6
Нийтийн тээврийн үйлчилгээнд хүрэхэд хүнд	0.6	0.0	0.0	2.2
Танил тал, төрөл садангийн дэмжлэг байхгүй	2.1	2.7	2.4	1.1
Хариулахыг хүсэхгүй	0.0	0.0	0.0	0.6
Бусад	2.7	2.7	1.2	2.2
Өрхийн тоо	339	37	84	181

Тэмдэглэл: Асуулт олон сонголттой хариулттай тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү гарч болно.

Өрхүүдийн хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар хөдөөгийн шилжин суурьшсан газарт илүү өндөр байна. Тэдэнд гэр бүл, найз нөхдийн тусламж дэмжлэг хамгийн чухал**.** Шилжин суурьшсан нутагтаа хүндрэл бэрхшээлтэй тулгарсан өрхүүдээс хөдөөгөөс хот руу шилжигч өрхүүд хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар бусадтайгаа харьцуулахад сул байна. Хотоос хөдөө рүү шилжсэн өрхүүд хүндрэл бэрхшээлээ бараг бүгдийг даван туулж чадсан байна. Асуудлыг шийдвэрлэх стратеги талаас нь авч үзвэл, өрхүүдийн дийлэнх нь төрөл садан, найз нөхдийн дэмжлэг, туслалцаатайгаар хүндрэл бэрхшээлийг давж чадсан байна. Жишээлбэл, эцэг эх, хүүхдүүд болон бусад хамаатан садангийн тусламж бүх шилжин суурьшсан газарт өндөр байгаа бөгөөд хоорондын зөрүү тийм их биш байна. Харин хүндрэл бэрхшээлээ даван туулж

чадаагүй өрхүүдэд тохиолдсон нийтлэг асуудал нь мөнгөгүй, эсвэл эдийн засгийн чадавх муу гэж хариулсан байна.

Шигтгээ 6: Шилжин суурьшсан нутагт тохиолдсон хүндрэл бэрхшээлийн талаарх чанарын мэдээллээс

Сэлэнгэд ажилгүй, ажил олдохгүй, хотод ажилд орж амьжиргаагаа дээшлүүлэх санаатай нүүсэн. Хотод нүүж ирэнгүүт ажил олдоогүй, гэвч ажилд орсон чинь орох оронгүй, Төв аймагт байгаа хамаатны гэрт байж тэндээс ажил руу явдаг байсан. Дараа нь Улиастайд газрын зөвшөөрөлтэй болоод жижиг байшин барьсан. Тэгсэн ч гэсэн идээшиж дасахгүй хэцүү юм билээ. Улиастайд байхдаа цөөн хэдэн үхэртэй болоод би ажилдаа яваад эхнэр маань үхэр малаа хариуцаад, хүүхдээ хардаг байлаа. Том хүү сургуульд орсон гэвч бага нь цэцэрлэгт орон тоо байхгүй гэж орж чадаагүй, одоо гэртээ байгаа. Миний сарын цалин 400–500 мянган төгрөгөөр яахав амьдралаа арай гэж нэг залгуулаад болж байна. Хийснээр цалинждаг болохоор илүү их ажиллах хэрэгтэй болсон. Улаанбаатар хотод мал байлгахгүй гээд тэгээд ч идээшиж дасахгүй болохоор хашаа байшингаа зараад Сэлэнгэ нутагаа буцаж ирсэн.

–Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэн, 33 настай А.

5.3. Шилжилтийн бүртгэл

Шилжигч өрхийн оршин суусан газраа бүртгүүлсэн байдал Улаанбаатарт хамгийн бага байна. Мөн Дорноговь аймгийн хот, хөдөөд шилжин ирэгчдийн аль алины хувьд үл ялиг бага байна. Зураг 24–өөс харахад, хэдийгээр Монгол Улсын хуулиар хүн ам шилжин ирсэн газраа хаягийн хөдөлгөөнөө шинэчлүүлж заавал бүртгүүлэх ёстой боловч шилжин суурьшсан өрхүүдийн бүртгэл зарим газар харьцангуй бага байгаа нь харагдаж байна. Ялангуяа, Улаанбаатар хотод шилжин ирэгч өрхүүдийн бараг тал хувь бүртгүүлээгүй байгаа ба энэ нь 2017 оны нэгдүгээр сараас 2020 хүртэл мөрдөх шилжих хөдөлгөөний хоригтой холбоотой байна. Бүртгэл нь нийгмийн суурь болоод халамжийн үйлчилгээ хүртэхэд зайлшгүй чухал бөгөөд ажилд орох, засаг захиргааны түвшинд хууль ёсны эрхээ эдлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой билээ. Иймд шилжилтээ хийлгээгүй, бүртгэлгүй өрхийн хувьд нэлээд сөрөг үр дагавартай гэсэн үг.

Бүртгэлээ хийлгэсэн өрхийн дөнгөж гуравны нэг нь л хуулийн хугацаанд багтаан бүртгүүлсэн байна. Байнгын болоод түр суурьшил өөрчлөгдөхөд, иргэн бүр тухайн орон нутгийн бүртгэлийн байгууллагад 7–10 хоногт багтан бүртгүүлэх ёстой. Судалгаанд хамрагдсан шилжигч өрхүүдээс, зөвхөн гуравны нэг нь энэ хугацаанд багтаж бүртгэлээ хийлгэсэн бол үлдсэн хэсэг нь 6 сар ба түүнээс дээш хугацааны дараагаар бүртгүүлсэн байна. Бүртгэлээ хийлгэсэн хугацаа хамгийн урт нь Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн хот суурин газарт шилжин ирсэн өрхүүдийн хувьд байна.

Зураг 24: Шилжилтийн бүртгэл



Улаанбаатар хотод ирсэн шилжигч өрхүүд шилжих хөдөлгөөний бүртгэл хийлгээгүй нэг гол шалтгаан нь тэдний шилжилт түр зуурын байдагтай холбоотой байна. Шилжих хөдөлгөөн түр зуурын байсан ч шилжин суурьшилтийг мэдэгдэх ёстой байдаг. Улаанбаатар хотод ирээд бүртгүүлээгүй шилжигч бүх өрхийн дөрөвний гурав нь түр шилжсэн гэж хариулж байна. Түүнчлэн, бүртгэлээ хийлгээгүй өрхийн 20% нийслэлийн шилжих хөдөлгөөний хоригийн улмаас бүртгэлээ хийлгэж чадахгүй байна.

Бүртгэл хийлгээгүй өрхүүд шилжин суурьшсан нутагтаа хүндрэл бэрхшээлтэй учрах байдал илүү өндөр байна. Шилжилтийн бүртгэлээ хийлгээгүй шилжигч өрх бүртгүүлсэн өрхтэй харьцуулахад хүндрэл бэрхшээлтэй учрах байдал бараг 20 хувиар илүү байна (72% ба 54%). Бүртгэлгүй өрхөд тохиолдсон хүндрэл бэрхшээлийн төрлийг авч үзвэл, орон байр олдохгүй, газрын зөвшөөрөл авч чадахгүй, ажил хайгаад олдохгүй, түүгээр ч үл барам нийгмийн халамжийн үйлчилгээ, мөн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнээс хүртэх боломж хумигдсан зэргийг нэрлэж байна.

Шигтгээ 7: Бүртгэлтэй холбоотой чанарын мэдээллээс

Гэр хорооло нийтийн олон байр байдаг. Тэнд байгаа оршин суугчдыг бүртгэж чадахгүй, их хэцүү. Хаанахын хэн байдаг, бүртгэлтэй бүртгэлгүй юм уу гээд маш олон хүндрэлтэй асуудлуудтай тулгардаг. Хөдөө орон нутгаас шилжин ирсэн олон өрхүүд нэг хашаанд нэг дор буучихсан, хамаатан эсэх нь бүү мэд баахан түр оршин суугчид л байдаг ш дээ. [...] Түрээсээр амьдарч байгаа залуу гэр бүлүүд бүртгүүлэхгүй байх нь элбэг, тэгээд жирэмсэн болчихоод хяналтанд орж чадахгүй, төрөх болохоор төрөх газар хүлээж авахгүй гээд маш их асуудал үүсдэг. Бүртгэлтэй болов ч хаягандаа байдаггүй айл маш олон. Тэгсэн мөртлөө хүрч ирээд халамжаа аваад байдаг. Ер нь энэ түрээсийн асуудлыг

цэгцлэхгүй бол хамаг муу юм эндээс гарч байна. Үүнээс болоод хаана ч бүртгэлгүй "сул" хүмүүс дүүрчихээд байна. Нийслэлийн хүн амын тоонд ордоггүй бүх төлөвлөлт тоон үзүүлэлтийг будлиантуулаад хаана ч бүртгэлгүй тэнэж байна. Иргэд иргэнийхээ үүргийг биелүүлэхгүй, бүртгэлээ хийлгэхгүй, төрийн хуулинд захирагдахгүй л юм бол эрх ашиг нь зөрчигдөх нь ойлгомжтой шүү дээ. За үүнээс гадна нүүгээд шинээр очсон өөр газар орчихоод холбогдох албаныханд ч мэдэгдэхгүй, гэр хорооллын хуучин хаягаа ч өөрчлөхгүй тохиолдол цөөнгүй бий. Яагаад ингэж байгаа юм бэ гэхээр хуучин хорооноос тусламж авахад амар байдаг гэж байгаа юм, мэдээж ингэснээр тэд янз бүрийн бичиг цаасны ажил хөөцөлдөх хэрэггүй болдог байхгүй юу. Хүмүүсийн шилжих хөдөлгөөнийг зохицуулсан хууль бий гэвч хэрэгждэггүй юм. Бүртгэл хариуцаж байгаа хүнийг торгох эрхтэй болгож, бүртгүүлэх хугацааг нарийн чанд болгох шаардлагатай. Зөрчлийн тухай хуульд 20 000 төгрөгөөр торгоно гэж хуульчилсан, түүн дээр бүртгэлийн хөлс ердөө 2500 төгрөг буюу 10 дахин бага байгаа хэдий ч үүнийг их мөнгө гэж үзээд шилжих хөдөлгөөнийг бүртгүүлэхгүй яваад өгдөг. Манай хороо интернэт сүлжээгүй болохоор бүртгэлээ сүлжээтэй хороон дээр очиж хийлгүүлдэг.

–Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 8–р хорооны улсын бүртгэгч А.

[…] Шилжин ирж байгаа хүмүүст эрүүл мэнд, боловсрол, өрхийн амьжиргаа, жирэмсний хяналтын үйлчилгээнд бүртгэж байгаа ч үйлчилгээг 100% авч чаддагүй. Оюутнууд хотын төвд байр түрээслэж амьдардаг ч захын хорооллын түр оршин суугч гэж бүртгэж өгөөч гээд тодорхойлолт авдаг. Тэд анх бүртгүүлсэн дүүрэгтээ амьдардаггүй, энд байгаа хамаатнынд амьдардаг. Монгол Улсын Үндсэн хуулиар тус улсын иргэн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй гэж заасан байтал өрхийн эмнэлэг "түр оршин суугч"–ийн үнэмлэхээ авч ир гэдэг болохоор Үндсэн хуулийн энэ заалт хэрэгжихгүй байна. "Түр оршин суугч"–ийн үнэмлэхээр мөнгө олох бизнес хийж байна. Жирэмсэн эхийг заавал "түр оршин суугч"–ийн үнэмлэх авч ир гэдэг ч амаргүй. Холын захын хорооло амьдарч байгаа бол нийтийн тээврээр хөнгөлөөттэй зорчих виза карт авах нь ашигтай. Зөрчлийн тухай хуулиар Монгол Улсын иргэн хаана ч эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдаж, халамжийн үйлчилгээ хүртэх ёстой ч үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна.

–Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 9–р хорооны зохион байгуулагч Э.

Бүртгэлгүй өрхүүд олон байна. Зарим нь хөдөө явчихаад буцаж ирээд хоригоос болж бүртгүүлж чадахгүй байна. Бүртгэлгүй болохоор нийгмийн суурь үйлчилгээнээс хүртэж чадахгүй байна. Жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхэд хоёр л өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх эрхтэй, харин бусад хүмүүс үйлчлүүлж чадахгүй байна. Бүртгэлгүй эхчүүд ганцхан Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд очиж төрж болно. Гэвч тэндхийн оочер дугаар гэж тамтаггүй байдаг гэсэн.

Өвдвөл хувийн эмнэлэгт л очиж төрөхөөс өөр арагүй. Мөнгөгүй бол тэгээд л өнгөрөө. Сургууль, цэцэрлэгт түр оршин суугчийн үнэмлэхээр бүртгүүлдэг гэвч цэцэрлэгийн хүртээмж муу. Хотоос шилжин явагсад хаягийн бүртгэл хийлгэх дургүй, одоо бүүр хийлгүүлэхгүй байгаа, яагаад гэвэл Улаанбаатарт шилжилт хөдөлгөөнийг зогсоосон учир буцаж хотод ирэхэд хэцүү болно. Бас эмнэлэгт үзүүлэхэд хотын харьяалалтай байх хэрэгтэй гэдэг. Ер нь хоёр хаягтай хүмүүс олон бий, нэг хүнийг 2 гэж тоолдог. Мөн хаягандаа бүртгэлгүй айл өрх олон байна.

– Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 5–р хорооны хэсгийн ахлагч Б.

... Шилжин явагсад шилжин ирэгсдээс цөөн. Ер нь хотод шилжин ирэгчид эхлээд гэр хорооллоор дамждаг. Учир нь тэнд шаардлага багатай. Нэг хашаан дотор 3–6 айл амьдардаг. Хичнээн хязгаар хориг тавьсан ч бүртгэлгүй хүмүүсийн тоо их байна. Шилжих хөдөлгөөнийг хорьсоноос болж бүртгэлгүй 1000–аад өрх байна. Хориг хязгаартай ч хүмүүс олноор шилжин ирж байна.

–Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 9–р хорооны зохион байгуулагч Э.

5.4. Шилжилт хөдөлгөөний дараах өөрчлөлт, сайжралт

Шилжин суурьшсанаас хойш өрхийн нөхцөл байдал сайжирсан эсэх талаар шилжигчдийн үзэл бодлыг тандахад, шилжилтийн урсгал, амьдралын онцлог байдлаас шалтгаалан тэдний үзэл бодолд ялгаа ажиглагдаж байна. Хүснэгт 11–д шилжигч өрхийн амьдралд гарсан янз бүрийн нааштай өөрчлөлт, сайжралтыг харуулж байна. Ерөнхийдөө, шилжин суурьшсанаас өрхийн амьдралын нөхцөл байдал доройтсон гэж үзэх хүмүүс маш цөөн байна, харин дээрдээгүй хэвэндээ байна гэж үзэж байгаа нь дийлэнх олонх байна. Гэхдээ шинэ газар шилжигч өрхийн дийлэнх хувь нь ажил хөдөлмөртэй болсноор амьдрал сайжирсан гэж үзэж байна. Сонирхолтой нь энэ тоо хөдөө орон нутаг руу шилжсэн шилжигчдийн хувьд арай илүү байгаа нь шилжин суурьшахаас өмнө ажил хөдөлмөр олдохгүй байсантай холбоотой байж болох талтай. Хотод шилжин суурьшсан өрхийн нэлээд олон хувь нь хөдөө байсантайгаа харьцуулахад, хүүхдийн сургалт, боловсрол, мэргэжлээр ажиллах, орон байрны нөхцөл, эрүүл мэндийн тусламж, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх боломж, нийтийн тээвэр, дэлгүүр зах, чөлөөт цаг өнгөрөөх зэрэг олон талаар сайжирсан гэж үзэж байна.

Өрхийн нөхцөл байдал шилжин суурьшсаны дараа муудсан гэж үзэж байгаа шилжигч өрхийн дийлэнх нь хотоос хөдөө рүү шилжигчид байна. Өрхийн нөхцөл байдал олон талаар муудсан гэж хариулсан шилжигч өрх цөөхөн байгаа ч зарим нэг байдал анхаарал татаж байна. Тухайлбал, хөдөөнөөс хөдөө дотор шилжигч өрхийн 16% нь орон байрны нөхцөл дордсон гэж хариулсан бөгөөд энэ үзүүлэлт шилжилтийн бусад урсгалтай харьцуулахад өндөр байна. Үүнтэй нэгэн адил, хот суурин газраас хөдөө орон нутаг руу шилжсэн өрхийн

харьцангуй өндөр хувь нь хүүхдийн боловсрол, сургалт муудсан, мөн нарийн мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээ, нийтийн тээврийн байдал дордсон гэж хариулжээ.

Хүснэгт 11: Шилжилт хөдөлгөөний дараа гарсан сайжралт (%)

	Хөдөө–хот	Хөдөө–хөдөө	Хот–хөдөө	Хот–хот
Хөдөлмөр эрхлэлт	59.3	67.6	63.1	59.1
Боловсрол, мэргэжлийн үр чадвар	41.6	32.4	15.5	45.3
Хүүхдийн боловсрол	43.1	18.9	17.9	38.1
Гэр бүлийн харилцаа	33.0	24.3	31.0	35.9
Найз нөхөд, төрөл садангийн харилцаа	31.6	24.3	34.5	34.8
Орон байрны нөхцөл	37.8	18.9	32.1	43.6
Эрүүл мэндийн үйлчилгээ	25.7	10.8	11.9	27.1
Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үйлчилгээ	43.7	8.1	3.6	38.7
Нийтийн тээвэр	54.3	10.8	14.3	46.4
Зах, худалдан авалт, худалдаалах	62.5	35.1	53.6	56.9
Амьдралын сэтгэл ханамж ба орчин	42.8	29.7	48.8	47.5
Чөлөөт цаг	27.4	10.8	21.4	26.5
Нийгмийн оролцоо	31.0	29.7	22.6	38.7
Өрхийн тоо	339	37	84	181

Шигтгээ 8: Өрхийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтийн талаарх чанарын мэдээллээс

... Улаанбаатар хотод ажилгүй байсан ч зах дээр тэрэг түрээд, хоол хийж зараад амьдарчихдаг гээд л наашаа зүтгээд байгаа. Тэр нь үнэн байхаа. Хөдөө хөгжил битгий хэл ажлын байр ч байхгүй юм чинь дээ.
–Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 8–р хорооны улсын бүртгэгч А.
... Хүүхдүүдтэйгээ хамт сайхан л байна. Энд худалдааны төвд лангуу түрээсээр ажиллуулж байна. Тэтгэврийн над шиг хүнд бол аятайхан. Эмнэлгийн үйлчилгээ жаахан хэцүү, эмнэлэгт үзүүлэх болохоор Дархан–Уул аймаг руу явдаг. Тэр нь ч амар байдаг. Энд шилжсэн тухайгаа бүртгүүлээгүй, түр оршин суугч гэж бүртгэгдсэн. Би бүрмөсөн шилжих бодолгүй, Дархан руугаа буцаж явна гэж бодож байна.
–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн
6–р хорооны шилжигч, 61 настай Х.

Янз бүрийн айл өрх бий. Ажилд ороод амьдрал нь сайжирч байгаа өрхүүд бий. Эсвэл хөдөөнөөс ирээд амьдрал нь хөдөө байснаас нэг их дээрдээгүй хэвийн байгаа айлууд ч байгаа. Тогтмол ажилтай өрхүүд болон хувь хүмүүсийн амьдрал сайжирдаг. Зарим айл хамаг малаа зараад хот руу зүглэдэг, ирээд ажилд орж чадахгүй амьдрал нь улам дороойтсон айл бишгүй л байна.
–Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн
22–р хорооны зохион байгуулагч Д.

6. ИРЭЭДҮЙН ШИЛЖИЛТ

6.1. Ирээдүйн шилжилт

Шилжигч болон шилжигч бус өрхүүдийн дийлэнх олонх нь одоогийн суурьшиж буй газраа байнга оршин суурьших төлөвлөгөөтэй байгаа нь тэдний цөөхөн хувь нь ирээдүйд аль нэг тийшээ шилжих бодолтой байна гэсэн үг. Дээрх хоёр бүлэг дотор одоо оршин суугаа газарт байнга байх гэсэн бодолд мэдэгдэхүйц ялгаа байхгүй байна, харин энэ хоёр бүлэг өрхийн 13 орчим хувь нь ирээдүйд шилжих хөдөлгөөн хийж магадгүй гэсэн байдалтай байна. Хот, хөдөөгийн байршлаар авч үзвэл, хөдөөгийн шилжигч өрхүүд нь шилжигч бус өрхүүдтэй харьцуулахад шилжин суурьших сонирхол (тус бүр 13% ба 19% байна) нь ялимгүй өндөр байна. Харин хот суурин газрын өрхүүдийн хувьд энэ ялгаа бараг үгүй байна.

Хөдөөгийн шилжигч бус өрхүүд ирээдүйд шилжихийг хүссэн чиглэлд нийслэлийг нэрлэж байгаа бол хотын шилжигч өрхийн хувьд харин эсрэгээр байна. Зураг 25 ирээдүйд шилжих хүсэлтэй, потенциал шилжигч өрхүүдийг хот, хөдөөгийн байршлаар, шилжилтийн статусаар харуулж байна. Сонирхолтой нь хөдөөгийн шилжигч бус өрхүүд нийслэл рүү шилжих хүсэл өндөр байгаа бол хотын шилжигч өрхүүдийн хувьд сум, эсвэл хөдөө рүү шилжихийг эрхэмлэж байна. Аймгийн төв нь бүх бүлгийн хувьд мөн шилжихийг хүссэн нийтлэг газраар нэрлэгдэж байгаа ч хотын шилжигч бус өрхүүдийн хувьд нийслэлийг бус бусад өөр хот суурин руу нүүхийг илүүд үзсэн байна. Мөн цөөхөн өрхийн хувьд гадаад руу шилжихийг хүссэн байгаа ба ялангуяа, хөдөөгийн шилжигч өрхүүдийн хувьд ийм сонирхол илүү байна.

Зураг 25: Ирээдүйд шилжихийг хүссэн газар нутаг



Ирээдүйд шилжих байдал шилжин суурьших нутгаас ихээхэн шалтгаалж байна. Хэрвээ шилжих газар нийслэл байхын бол амьжиргаагаа дээшлүүлэх хамгийн гол зорилго байх болно гэж үзжээ. Аймгийн төв, сумтай харьцуулахад энэ нь харьцангуй өндөр хувийг эзэлж байна. Бусад хоёр газартай харьцуулахад нийслэл рүү шилжихийг хүсэгчдийн бас нэгэн шалтгаан нь хүүхдийн боловсролын хүртээмж байна. Харин эсрэгээрээ, сум руу шилжихийг хүсэгчдийн хувьд хамаатан садандаа ойртох байдал гол шалтгаан болохоор байгаа бол аймгийн төв рүү шилжихийг хүссэн өрхийн гол шалтгаан нь эрүүл мэндийнх байна.

Шилжигч болон шилжигч бус өрхүүд одоогийн суурьшсан газраа байнгын суурьшилтай болохыг яагаад эрхэмлэж байгаа нь нэлээд ялгаатай харагдаж байна. Тухайлбал, дахин шилжих төлөвлөгөөгүй шилжигч өрхүүд ажил эрхлэх боломж, амьдрах таатай орчин, амьжиргаа сайжирсан зэргийг цаашид эндээ суурьших шалтаг хэмээн нэрлэжээ. Харин хот, хөдөөгийн шилжигч бус өрхүүд шилжигчидтэй харьцуулахад энэ газраа илүү дасан зохицож чадсан гэж хариулсан байна. Мөн аль ч бүлгийн хувьд хамаатан садантайгаа ойрхон байгаа учраас эндээ суурьшихийг чухалчилсан байна.

6.2. Буцах шилжих хөдөлгөөн

Шилжин суурьшсан бүх өрхүүд тодорхой хугацаагаар уугуул нутаг руугаа зочилж очих нь нэлээд түгээмэл байна. Шилжигч өрхүүдийн дөрөвний гурав орчим нь уугуул нутагтаа тодорхой хугацаагаар зочилж очдог бөгөөд хотоос хөдөө рүү шилжигч өрхийн хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 86% байна (нийслэл болон бусад хот суурин газар руу буцаж очих байдал). Нөгөөтэйгүүр, хөдөөгөөс хот суурин газар луу шилжин суурьшсан өрхүүдийн хувьд буцах байдал хамгийн бага буюу 70% байгаа нь ийм айл өрх уугуул нутаг руу буцаж очих боломжоор муу, эсвэл буцаж очих сонирхолгүй байдаг байна.

Уугуул нутагтаа богино хугацаагаар очиж байгаа шилжигч өрхүүдийн дийлэнх нь 7 хоног буюу түүнээс ч богино хугацаагаар заримдаа нэг сараас илүүгүй хугацаагаар ирж очдог байна. Зураг 26–д уугуул нутагтаа буцаж очихдоо зарцуулдаг дундаж хугацааг шилжилтийн урсгалаар харуулав. Сонирхолтой нь, хөдөөд шилжин ирсэн шилжигч өрхийн гишүүд уугуул нутаг болох хот суурин газартаа тогтмол эргэн очдог байна. Бусад урсгалтай харьцуулахад тэд мөн харьцангуй богино хугацаанд тэнд байж байгаад ирдэг байна. Хөдөөд шилжин ирсэн өрхүүдийн 53% хот суурин газраа эргэн очиж, тодорхой хугацааны дараа буцаж ирдэг байна. Харин хотын шилжигч өрхүүдээс хөдөө болон бусад хот суурин газар руугаа очиж тодорхой хугацаанд байж байгаад ирэх байдал харьцагуй өндөр байна.

Зураг 26: Уугуул нутагтаа зарцуулж буй дундаж хугацаа



Аль ч тохиолдолд хамаатан садангийндаа зочлох шалтгаанаар буцаж очих байдал давамгайлж байна. Уугуул нутагтаа буцаж очдог шилжигч өрхүүдийн дийлэнх нь тэнд очоод гэр бүлийнхэнтэйгээ цагийг хамт өнгөрүүлдэг байна. Ерөнхийдөө, харьцангуй бага буюу 6% нь ажил эрхлэлттэй холбоотой шалтгаанаар буцах шилжилтэд оролцдог бөгөөд хот хөдөөгийн хооронд мэдэгдэхүйц онцын ялгаа алга байна.

Шилжигч өрхүүдийн талаас илүү хувь нь ямар нэг шалтгаанаар уугуул нутагтаа байнга суурьших зорилгоор буцан очихыг хүсэхгүй байна. Учир нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогын дутмаг байдал, ялангуяа, хот суурин газар ирээд ажил хөдөлмөрийн боломжтой болсон иргэдийн хувьд буцах сонирхол алга байна. Хотод шилжин ирсэн олон өрхийн хувьд уугуул нутаг дахь эрүүл мэнд, боловсролын үйлчилгээтэй холбоотой бодлогын сул байдлаас шалтгаалан буцахыг хүсэхгүй байна. Хөдөөгөөс шилжин ирсэн өрхүүдийн хувьд хөдөөгийн хөгжлийн бодлогын дутмаг байгааг байнга онцолж байсан бол хотоос шилжин ирэгчдийн тухайд байгаль орчны бохирдол буцахгүй байх гол шалтгаан болж байна.

Хөдөлмөрийн нөхцөл сайн болбол ирээдүйд нутагтаа буцах талаар бодож болох тухай шилжин суурьшигч өрхүүд өгүүлж байна. Хүснэгт 12–д шилжигч өрх уугуул газар нутагтаа буцая гэж бодвол ямар өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн байх ёстойг харуулж байна. Хамгийн нийтлэг асуудал бол хөдөлмөрийн илүү нөхцөл байдал чухал. Илүү сайн дэд бүтэц, амьдралын илүү таатай орчин зэргийг нэн ялангуяа хот, хөдөө уугуул нутаг руу буцах бодолтой хөдөөгийн шилжин суурьшигч өрх онцолж байна. Хотод шилжин суурьшиж байгаа өрхүүд, ирээдүйд ямар бодолтой байгааг илэрхийлэхэд хамгийн түрүүнд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах нь хамгийн чухал асуудал гэж үзэж байна.

Хүснэгт 12: Уугуул нутаг руу буцаж шилжихийг дэмжихийн тулд авах ёстой бодлогын арга хэмжээ (%)

	Хөдөө–хот	Хөдөө–хөдөө	Хот–хөдөө	Хот–хот
Дэд бүтцийг сайжруулах	46.1	37.5	57.5	36.4
Орон байрны нөхцөлийг сайжруулах	32.6	37.5	32.5	33.0
Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх	42.6	31.3	22.5	29.5
Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах	66.7	87.5	72.5	56.8
Өндөр чанартай эрүүл мэндийн байгуулагуудтай болох	27.0	6.3	7.5	22.7
Өндөр чанартай боловсролын үйлчилгээтэй болох	19.9	6.3	10.0	17.0
Засаг захиргааны илүү боловсронгуй дүрэм журамтай болох	32.6	37.5	20.0	21.6
Сайн засаглал	13.5	6.3	7.5	9.1
Амьдралын илүү сайн орчинтой болох	32.6	50.0	37.5	36.4
Мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх	11.3	12.5	5.0	3.4
Ялгаварлан гадуурхалтаас хамгаалах	3.5	6.3	7.5	2.3
Хариулахыг хүсэхгүй байна	0.0	0.0	2.5	1.1
Мэдэхгүй	0.7	0.0	2.5	0.0
Бусад	6.4	0.0	7.5	3.4
Өрхийн тоо	141	16	40	88

Тэмдэглэл: Асуулт олон сонголттой хариулттай тул хариултын хувийн жингийн нийлбэр 100 хувиас илүү гарч болно.

Шигтгээ 9: Буцах шилжих хөдөлгөөнийг дэмжихтэй холбоотой чанарын мэдээллээс

Би уугуул нутаг руугаа буцах тухай бодохгүй байна. Хэрэв төр засаг дахин малжуулах хөтөлтөр хэрэгжүүлбэл би Цагааннуур сум руу нүүх байх. Бусдаар тэнд очоод надад хийх ажил олдохгүй, тиймээс би буцахгүй. Би энд байнга оршин суух бодолтой байна.

–Сэлэнгэ аймгийн Баянгол сумын иргэн, 32 настай О.

7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

7.1. Дүгнэлт

Энэ тайлан Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөний талаар хамгийн сүүлийн үеийн тоо баримтыг танилцуулж байна. Судалгаанд хамрагдсан 1,001 өрхийн 3,715 хүн амын хувьд, уугуул болон шилжин суурьшсан нутаг хоорондын ялгаатай байдлаар дүн шинжилгээг хийсэн. Мөн статистик тоо мэдээлэлд нэмэлт тайлбар болгох үүднээс чанарын судалгааны арга, тухайлбал, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Ийнхүү судалгааг холимог аргачлалаар явуулснаар, судалгааны үр дүн дотоод шилжих хөдөлгөөний асуудлаар ажилладаг болон сонирхдог бодлого боловсруулагчдад үнэ цэнэтэй мэдээлэл болж байгаа юм.

Дүгнэж үзвэл Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн уугуул болон шилжин суурьшсан нутаг хоорондын эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн тэнцвэртэй бус байдлаас ихээхэн шалтгаалж байгааг онцлох хэрэгтэй. Энэхүү тайланд тодотгон харуулсан шилжих хөдөлгөөний өнөөгийн хандлагыг өнгөрсөн 15–20 жилийнхтэй харьцуулж болохоор байгаа бөгөөд ойрын ирээдүйд энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байна. Тоон болон чанарын судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ***Шилжих хөдөлгөөн хотжилтод хувь нэмэр оруулсан хэвээр байна.*** Шилжих хөдөлгөөний хөдөөнөөс хот суурин газар руу чиглэсэн 4 урсгалын хувьд ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал давамгайлж байна. Шилжих хөдөлгөөний урсгал аймгаас хамаарч өөр өөр байна, тухайлбал, Сэлэнгэ, Дорноговь аймгийн хувьд хот суурин газраас хөдөө орон нутаг руу чиглэсэн урсгал илүү байна.
- ***Шилжигчид хотын хөдөлмөрийн зах зээл дээр хөдөлмөрлөх боломж хайсан ихэвчлэн залуу насны хүмүүс байна.*** Шилжигчдийн дийлэнх нь 25–39 насны, хөдөлмөрийн насны насанд хүрсэн хүмүүс байна. Тэд хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах боломжийг эрэлхийлэн уугуул нутгаа орхиж явж байна. Гэвч хотын хөдөлмөрийн зах зээлийн албан секторт ажлын байр харьцангуй хомс байдаг учраас тэдний ихэнх нь албан бус секторын тодорхой бус нөхцөлтэй үйл ажиллагаанд оролцож байна.
- ***Шилжигчид үндсэндээ эдийн засгийн шалтгаанаар уугуул нутгаа орхин явж байна.*** Шилжигч өрхүүдийн дийлэнх олонх нь нүүхээс гарцаагүй нөхцөл байдлын улмаас шилжиж суурьшаагүй байна. Харин ажлын байр хомс, амьжиргаагаа дээшлүүлэх боломж байхгүйгээс уугуул нутгаа орхин шилжиж байна. Шилжин суурьшсан нутгаа сонгож буй шалтгаан янз бүр байна. Зөвхөн эдийн засгийн шалтгаанаас бус харин гэр бүл, төрөл саданд ойртох, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ илүү сайн байгаа зэрэг шалтгаанаар шилжин суурьшсан нутгаа сонгох нь илүү байна.
- ***Шилжихээсээ өмнө шилжин суурьшсан нутгийнхаа талаар мэдээлэл олж авах байдал хязгаарлагдмал байна.*** Шилжигч өрхүүдийн дийлэнх нь шилжин суурьших гэж байгаа газар нутгийн талаар ямар нэг

мэдээлэлгүйгээр шууд шилжин суурьшиж байна. Мэдээлэлтэй байсан шилжигч өрхүүд ихэвчлэн гэр бүлийн бусад гишүүд, найз нөхдөөс мэдээлэл авсан байна.

- ***Шилжихээсээ өмнө шилжигч өрхүүд уугуул нутагтаа ихэвчлэн эдийн засгийн шинж чанартай хүндрэл бэрхшээлтэй учирдаг байсан бол шилжин суурьшсан нутагт ирсний дараа амьжиргаа/ахуйн нөхцөлтэй холбоотой асуудалтай тулгардаг байна.*** Шилжигч өрхүүдэд уугуул нутагтаа тохиолдож байсан хамгийн гол бэрхшээлд ажлын байр байхгүй, орлогын эх үүсвэргүй зэрэг асуудлууд орж байжээ. Харин шилжин суурьших гэж ирсэн нутагт орон байр болон газрын зөвшөөрөлтэй холбоотой бэрхшээлүүд илүүтэй тохиолддог байна.
- ***Шилжигч өрхүүдийн дунд шилжих хөдөлгөөний бүртгэлийн түвшин харьцангуй доогуур байна, энэ нь нэн ялангуяа, Улаанбаатарт хамгийн бага байна.*** Шилжих хөдөлгөөний бүртгэлгүй шилжигч өрхийн тоо нийслэлд хамгийн өндөр, Дорноговь аймагт бага байна. Шилжих хөдөлгөөннийг бүртгүүлсэн өрхүүдийн дийлэнх олонх нь бүтгэлийг хуулийн заасан хугацаанд хийгээгүй байна. Улаанбаатарт байнга оршин суух шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийлгүүлээгүй гол шалтгаанд суурьшил түр зуурынх, цаашилбал нийслэл хот рүү шилжих хөдөлгөөнийг зогсоосонтой холбоотой байна.
- ***Шилжигч өрхийн маш цөөн хувь нь шилжиж суурьшсаны дараа тэдний амьдрал дордсон гэж үзэж байна.*** Шилжигч өрхийн дийлэнх хувь нь маш олон үзүүлэлтээр, ялангуяа, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой амьдралын нөхцөл сайжирсан гэж үзэж байна.
- ***Судалгаанд хамрагдсан бүх өрхүүд цаашдаа шилжин суурьших сонирхол бага байна.*** Шилжигч болон шилжигч бус өрхүүдийн дийлэнх хувь нь нүүж суурьшсан газартаа байнга оршин суух бодолтой байна, өөрөөр хэлбэл, ирээдүйд шилжих төлөвлөгөөгүй байна. Шилжигч өрхүүд уугуул нутаг руу хамаатан садантай уулзахаар тогтмол очдог байна, харин шилжигч өрхүүдийн талаас илүү хувь нь уугуул нутаг руу бүрмөсөн буцах сонирхолгүй байна.

Энд өгүүлсэн судалгааны дэлгэрэнгүй үр дүнгээс гадна тайлан бүхэлдээ хэд хэдэн шалтгаант асуудлыг хөндсөн. Нэгд, өрхийн аж байдлын талаас шилжигч болон шилжигч бус өрхүүдийг харьцуулж ойлгох нь уугуул болон шилжин суурьшсан нутаг аль алинд нь бодлого боловсруулахад ихээхэн чухал юм. Жишээлбэл, Улаанбаатар хотод нүүж ирсэн олон шилжигч өрх бүртгэлгүйгээс болж нийгмийн суурь үйлчилгээ авч чадахгүй байгаа нь амьжиргааны эмзэг байдлыг бий болгож байна. Энэ нь зөвхөн шилжих хөдөлгөөний тухай бодлого төдийгүй хотжилтын бодлоготой ч холбоотой. Хоёрт, өнөөгийн дотоод шилжих хөдөлгөөний мөн чанарыг ойлгосноор, ирээдүйн төлөвлөлтөнд чухал ач холбогдолтой. Энэ тайланд шилжигчид уугуул нутгаа орхиж байгаа гол шалтгаан, шилжин суурьших гэж буй нутаг юугаар онцгой байгаа, шилжигчид өөрсдийн тухайн нөхцөл байдлын талаар ямар үзэл бодолтой байдаг, мөн ирээдүйд шилжих хөдөлгөөнд оролцох хүсэл бодлыг нарийвчилж авч үзсэн байна. Дотоод шилжих хөдөлгөөний шинэчлэгдсэн энэхүү баримт нотолгоо, шилжилтийн эдгээр хандлагууд Монгол Улсын цаашдын хөгжилд нөлөөлж

болохыг тооцож үр өгөөжтэй төлөвлөгөө, арга зам боловсруулахад бодлого боловсруулагчдад тус нэмэр болох учиртай.

7.2. Зөвлөмж

Шилжих хөдөлгөөн нь Монгол Улсын нийгэм–эдийн засгийн хөгжлийн чухал хүчин зүйл мөн гэдгийг судалгааны үр дүн харуулж байна. Шилжих хөдөлгөөний хоёр тал буюу уугуул болон шилжин суурьшсан нутаг аль алинд нь үр нөлөө гарч байгаа тул бодлого боловсруулагчид шилжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлж, шилжилттэй холбоотой зардлыг бууруулахын тулд онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Дараах бодлогын зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

1. ***Хөгжлийн төлөвлөлт, салбарын болон салбар дундын бодлогод дотоод шилжих хөдөлгөөнийг анхаарах.*** Шилжих хөдөлгөөнд оролцож байгаа хүн амын дийлэнх хувь нь эдийн засгийн идэвхтэй, боловсролтой, хөдөлмөрийн насны залуучууд байна. Тийм учраас уугуул болон шилжин суурьшсан газар нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг эрчимжүүлж, төрөлжүүлэх зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг бэхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, шилжин суурьшихаар төлөвлөж байгаа газар нутагт эрэлт хэрэгцээтэй ажлын талаарх мэдээллээр хангах, холбогдох үр чадварын сургалт явуулах хөтөлбөрийг уугуул нутагт хэрэгжүүлбэл шилжин суурьшигч ажилчныг тохирсон мэргэжлийн ажлаар хангах боломжийг сайжруулна. Нөгөө талаар, ийм шинэлэг хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд нийгмийн салбарын төсвийг төлөвлөхдөө уугуул болон шилжин суурьших гэж байгаа газрын, ялангуяа Улаанбаатар хотын төсөвт шилжих хөдөлгөөнтэй холбоотой санхүүжилтийг төсөвлөх хэрэгтэй. Шилжигчдийг түр оршин суугч гэсэн байдлаар хандах биш харин тэднийг байнгын оршин суугчийн нэгэн адил үзэж төсөв төлөвлөлтийг үүнд нийцүүлэхээс гадна дүүрэг, хорооны хэмжээнд үзүүлж буй нийгмийн үйлчилгээний ачааллыг бууруулахад анхаарах хэрэгтэй.
2. ***Нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрт шилжигч хүн амыг хамруулах.*** Шилжих хөдөлгөөнд оролцсон өрхүүдийн эдийн засаг, нийгмийн үйлчилгээний боломж уугуул нутагтай харьцуулбал хавьгүй илүү байх боловч бүртгэлгүйн улмаас орон байрны боломж, газар эзэмших, ажлын байраар хангагдах зэрэг боломж ихээхэн хязгаарлагдмал байдаг учир эмзэг байдалд өртдөг. Иймд эдгээр өрхүүдэд шилжин ирснээс хойш тодорхой хугацаанд, жишээлбэл байнга оршин суух бүртгэлийн асуудлыг шийдэж, газар, орон байртай болох хүртэл нийгмийн хамгааллын бодлогоор дамжуулан төрийн болон нийгмийн, мөн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна.
3. ***Шилжигчдийн мэдээлийн хүртээмжийг сайжруулах.*** Шилжих хөдөлгөөнд оролцогч өрхүүд ихэвчлэн албан бус мэдээллийн эх үүсвэрээр буюу хамаатан садан, найз нөхдөөс шилжин суурьшихаар төлөвлөж буй газар нутгийн тухай мэдээллийг авч байна. Ийм мэдээллийг төр засаг албан сувгаар тухайлбал, олон нийтийн радио, телевиз, сонин сэтгүүлээр

олон нийтэд нээлттэй дамжуулж сурталчлах замаар хөдөлмөр, бизнесийн боломж орон байрны нөхцөл, үзүүлж байгаа үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

4. ***Буцах шилжих хөдөлгөөнийг дэмжих зорилгоор уугуул нутгийн амьдралын нөхцөлийг сайжруулах.*** Уугуул нутаг руу буцах шилжих хөдөлгөөний дэмжих бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх. Хөдөө орон нутгийн хөгжлийн бодлогод суулгах, ингэхдээ буцах шилжигчид, мөн шилжих сонирхолтой хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулах асуудлыг түлхүү анхаарах хэрэгтэй. Үүний нэгэн адил, энэ судалгаанд мөнгөн гүйвуулгын асуудлыг авч үзээгүй ч шилжин суурьшигчдийн хадгаламжийн чадвар, уугуул нутагт ирээдүйд буцаж шилжин нүүх бодлын хүрээнд мөнгөө уугуул нутаг руу шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжийг судлах хэрэгтэй.
5. ***Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгахад чиглэсэн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн бодлого боловсруулах.*** Хөдөөгийн, хүн амын амьжиргааны түвшин, амьдарч буй орчин нөхцөлийг сайжруулахад хөдөө болон бүс нутгийн хөгжлийн бодлого зайлшгүй чухал шаардлагатай байна. Хөдөөгийн хүн ам ажлын байр байхгүйгээс болж орлогогүй, амьжиргааны эх үүсвэргүй байна. Хүн амыг бизнес эрхлэх нөхцөл боломжоор хангах, хөдөлмөр эрхлэлтийн илүү сайн боломжуудыг бий болгохын тулд бичил зээлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж болно. Үүний нэгэн адил хөдөө орон нутаг руу шилжих сонирхолтой хот суурин газрын өрхийг урамшуулан дэмжих бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, их дээд сургуулиудыг нийслэл хотоос гадуур зарим аймгийн төв, хот суурин газарт барьж байгуулбал аж үйлдвэр, үйлчилгээний төвүүдийг нийслэлээс гадуур хөгжүүлэх боломжтой болно.
6. ***Шилжих хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах.*** Улаанбаатар хотод ялангуяа бүртгэлгүй шилжин суурьшигч өрхийн тоо маш өндөр байгааг харгалзан шилжигч өрхүүдийг бүртгэх бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй байна. Үүний хүрээнд шилжин ирсэн газарт цаг алдалгүй бүртгүүлэхийн ач холбогдлыг шилжин ирэгсдэд ойлгуулах арга хэмжээ зохион байгуулах. Нийслэлд байнга оршин суух шилжих хөдөлгөөнийг хориглосон шийдвэрийг эргэж харах нь ухаалаг алхам байж болох юм. Хоригийн улмаас зориудаар бүртгүүлэхгүй байгаа учир төр, нийгмийн үйлчилгээний хүртээмж буурч, хот дотор албан бус суурьшлын бүс өргөжиж байгааг бодолцох хэрэгтэй.
7. ***Шилжигч болон шилжигч бус хүн амын хооронд нийгмийн нэгдмэл байдлыг дэмжих зорилгоор мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх, хүндрэл бэрхшээлтэй асуудлыг даван туулахад шилжигчдэд тусалж дэмжих.*** Шилжих хөдөлгөөн тухайн нийгэм хамт олонд эерэг болон сөрөг нөлөөтэй. Монголын дотоод шилжих хөдөлгөөнийг илүү сайн ойлгож дэмжих зорилгоор олон нийт, төрийн байгууллагуудын захиргааны ажилтнуудыг зөв мэдээллээр хангахыг санал болгож байна. Шилжих хөдөлгөөний болзошгүй сөрөг үр дагаварыг бууруулахад чиглэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулахад чухал нөлөөтэй судалгаа шинжилгээний үр дүн, шилжигчдийн тухай статистик мэдээллийг дэмжих талаар анхаарах хэрэгтэй.

8. ***Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах ажлыг дэмжих зорилгоор шилжих хөдөлгөөний талаар үндэсний судалгаа шинжилгээг тогтмолжуулах.*** Монгол Улсын төрөлт, нас баралтын тухай нарийвчилсан мэдээллийг үндэсний хэмжээний судалгаагаар 3–5 жил тутам цуглуулдаг. Гэвч шилжих хөдөлгөөний талаар цаг үеийн сэдэвчилсэн судалгаа байдаггүй. Жишээлбэл, 10 жил тутам нэг удаа зохион байгуулдаг хүн ам, орон сууцны улсын тооллого шилжих хөдөлгөөний түвшин, урсгал, чиглэлийн талаар ерөнхий мэдээллийг цуглуулдаг. Шилжих хөдөлгөөний шалтгаан, үр дагавар эсвэл шилжигчдэд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийн тухай албан ёсны дэлгэрэнгүй статистик мэдээллийг цуглуулдаггүй. Шаардлагатай гэсэн үед түүвэр судалгааг үе үе хийдэг. Иймд хүн амын тоо, байршил тархалтыг өөрчилж байдаг хүн ам зүйн гурван гол бүрэлдэхүүн хэсэг болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнийг ижил түвшинд авч үзэн, шилжин хөдөлгөөний талаар тогтмол давтамжтайгаар явуулдаг үндэсний хэмжээний судалгааг бий болгох гарцаагүй шаардлага байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Aleshkovski I., and V. Iontsev

2009 Шилжих хөдөлгөөний математик загвар, Livchits, V. N. & Tokarev, V. V. (ред.), Интегралчлагдсан дэлхийн системийн загварчлал, шинжилгээний тогтолцоо, – Цуврал. *II*. Абу Дабу, Eolss хэвлэлийн газар.

Anqing, S.

2011 Хөдөөгөөс гадагш шилжих хөдөлгөөн – Монгол дахь хотын гэр бүлүүдийн амьдрал. Суурь судалгааны тайлан, Зүүн Өмнөд болон Номхон далайн орнуудын бүс/СиЭмЮ.Вашингтон: Дэлхийн банк

Анагаахын шинжлэх ухааны их сургууль (АШУИХС)

2007 Шилжигчдийн нийгэм–эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн үйлчилгээний хэрэгцээ, хүртээмжтэй байдал. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.

Батбаатар, М., Болд, Ц., Marshal J., Оюунцэцэг, Д, Тамир, Ч. Түмэннаст, С.

2006 Хүүхдүүд нүүж байна: Хөдөө–хот шилжих хөдөлгөөн ба хүүхдийн боловсролын хүртээмж. Тайлан No. 17. Лондон: Английн хүүхдийг ивээх сан.

Болормаа, Ц.

2006 Улаанбаатарын шилжилтийн таталцал, түүний үр дагавар. *Боловсролын докторын зэрэг горилсон бүтээл, Прага дах Карлын их сургууль, БНЧУ.*

Болормаа, Ц., Neupert, R., Энхцэцэг, Б., Гүнчинмаа, Т., Навч, Т., Цогтбаяр, Ч., Hayes, G.

2012 Монгол Улсын Хүн ам зүйн өөрчлөлтийн нийгэм–эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дах нөлөөлөл. Улаанбаатар: НҮБХАС.

de Haas, H.

2011 Дотоод шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч хүчин зүйлс: Уугуул болон шилжин суурьшсан нутаг дах үр нөлөө, бодлого. Судалгааны тайлан No.32, Төслийн баримт бичиг No.2, Дотоодын хөгжлийн хэлтэс, Олон улсын шилжих хөдөлгөөний институт, Оксфорд: Оксфордын их сургууль.

P. and C. Guiness

2012 Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн*:* Кэйс судалгаа. Geofile онлайн, 658. Nelson Thornes.

Зориг сан

2005 Төсөлд оролцогчдын судалгаа*:* Шилжигчидтэй хамт. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.

Khan, A. H.

2000 Дотоод шилжих хөдөлгөөний хөдөлгөгч хүчин зүйлс: АХС 1996–7. *The Pakistan Development Review*, *39*(4), 695–712.

Mahinchai, M.

2011 Танзани Улсын шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч хүчин зүйлс. Dar es Salaam хотын кэйс судалгаа: UTAFITI, сэтгүүл 1996 Цуврал 3, No.2, 169–184.

Memon, R.

2005 Пакистаны дотоод шилжих хөдөлгөөний хандлага, тодорхойлогч

хүчин зүйлс. ASEDP No. 72. Эдийн засгийн хөгжлийн институт – Японы Гадаад худалдааны байгууллага.
Mitchell, J. and N. Pain
2003 ИБ–ны олон улсын шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч хүчин зүйл: Панел арга зүй. NIESR Discussion Papers 216. Лондон: Нийгэм, эдийн засгийн судалгааны үндэсний хүрээлэн.
Msigwa, R.E and J.E. Mbongo
2013 Танзани Улсын дотоод шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч хүчин зүйлс. Эдийн засаг, тогтвортой хөгжлийн сэтгүүл, *4*(9), 28–35.
Нарантулга Б.
2013 Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн амьжиргааны түвшин. *Боловсролын докторын зэрэг горилсон бүтээл*. Удирдлагын академи, Улаанбаатар, Монгол Улс.
Sjaastad, L.A.
1962 Шилжих хөдөлгөөний зардал, үр ашиг. Улс төрийн эдийн засгийн сэтгүүл *70* (хавсралт), 80–93.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2002 Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэсэн сэдэвчилсэн бүтээл, Улаанбаатар, Монгол Улс.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2007 Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгаа. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2011 *2010* оны хүн ам, орон сууны тооллого: Шилжилт, суурьшилт. Тооллогын монограф, Улаанбаатар, Монгол Улс.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2011 Хүн ам, орон сууцны тооллого *2010:* Өмнөговь аймаг. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2016 2015 Хүн ам, орон сууцны завсрын тооллого: үндсэн тайлан. Улаанбаатар, Монгол Улс.
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)
2018 Хүн амын шилжих хөдөлгөөн: аймаг, хотоор. 2018 оны 8 сарын 23–нд шалгав. www.1212.mn/.
Хүн амын сургалт судалгааны төв (ХАССТ)
2001 Дотоод шилжих хөдөлгөөний макро түвшний судалгаа Монгол Улс 2000 он. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.
Хүн амын сургалт судалгааны төв (ХАССТ)
2005 Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.
Хүн амын сургалт судалгааны төв (ХАССТ)
2010 Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.
Эрүүл мэндийн хүрээлэн (ЭМХ)
2003 Дотоод шилжих хөдөлгөөн ба Нийгмийн эрүүл мэнд дэх үр дагавар. Судалгааны тайлан, Улаанбаатар, Монгол Улс.